




БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН

Захиалагч: ПРЕМИУМ НЭКСУС ХК

Гүйцэтгэгч: РИЗИЛИЕНС КОНСАЛТИНГ СЕРВИЗ ХХК



АГУУЛГА

- 03 ТАНЫ СОНОРТ
- 04 МЭНДЧИЛГЭЭ
- 05 ТАНИЛЦУУЛГА
- 06 АРГАЧЛАЛ
- 07 ХУРААНГУЙ
- 17 **ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО**
- 25 **БАЙГАЛЬ ОРЧИН**
- 26 ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭ
- 30 ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ
- 32 УУР АМЬСГАЛЫН ЭРСДЭЛ
- 33 УС
- 34 ХОГ ХАЯГДАЛ
- 36 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ
- 37 **НИЙГМИЙН ҮНЭЛГЭЭ**
- 38 ХҮНИЙ НӨӨЦ, ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ
- 44 ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ
- 50 НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА, ИЛ ТОД БАЙДАЛ
- 57 ТОГТВОРТОЙ ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ МЕНЕЖМЕНТ
- 58 **ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ**
- 59 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ
- 61 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД
- 64 ТУЗ
- 75 БОДЛОГО
- 78 САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ ХӨДӨӨ АЖ АХУЙ & ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ
- 79 ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДАД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

ТАНЫ СОНОРТ

Таны сонорт хүргэж буй энэхүү мэдэгдэл нь Премиум НэксусХК-ийн гаргасан Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ) тайлангийн хамрах хүрээ, хязгаарлалтыг тодруулах зорилготой юм. БОНЗ-ын тайлан нь бизнесийн оролцогч талуудын тогтвортой байдал, ёс зүйн практикийн төлөв байдлыг илэрхийлсэн байгаль орчин, нийгэм, засаглалын хүчин зүйлсийн хүрээнд хэрэгжүүлж буй компанийн хүчин чармайлт, гүйцэтгэл, санаачилгын талаарх мэдээллийг агуулах боловч дараах зүйлсийг болгоон үзнэ үү.

1. Тайлангийн ерөнхий шинж чанар: Тус тайлан нь зөвхөн мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн бөгөөд санхүү, хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын зөвлөгөө биш бөгөөд БОНЗ үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулсан мэдээллүүдийг тусгасан юм.

2. Мэдээллийн үнэн зөв байдал: Тус тайлан нь хамгийн сүүлийн үеийн, үнэн зөв мэдээллүүдийг агуулахыг зорьж байгаа ч энэ нь тодорхой таамаглал, тооцоолол, төсөөлөл, хэтийн төлөвийг агуулсан байж болно.

3. Хязгаарлагдмал хамрах хүрээ: Тус тайлан нь тодорхой БОНЗ-ын холбогдолтой үйл ажиллагаа дээр төвлөрсөн тул байгууллагын бүхий л үйл ажиллагааг тус тайлангаар дүгнэх боломжгүй болно.

4. Гадаад хүчин зүйлс: Байгууллагын БОНЗ-ын гүйцэтгэлд зохицуулалтын өөрчлөлт, зах зээлийн нөхцөл байдал, олон улсын хэмжээний үйл явдлууд зэрэг олон гадаад хүчин зүйлс нөлөөлөх боломжтой ба тус тайлан нь эдгээр хүчин зүйлсийн БОНЗ-ын гүйцэтгэлд үзүүлэх нөлөөг бүрэн судалж тусгаагүй байх магадлалтай юм.

5. Ирээдүйн гүйцэтгэл: Тус БОНЗ-ын тайланд байгууллагын ирээдүйн БОНЗ-ын зорилго, зорилт, эрмэлзлийн талаар агуулж болох ба эдгээр нь ирээдүйн БОНЗ-ын гүйцэтгэл, үр дүнгийн баталгаа биш болно.

6. Хэрэглээ ба хариуцлага: Бид БОНЗ-ын тайлангийн үнэн зөв байдлыг хангахын тулд хүчин чармайлт гарган ажиллаж байгаа хэдий ч тайлантай холбогдох аливаа алдаа, орхигдол, үл нийцэлтэй тооцоолол болон түүний агуулгад үндэслэн хийсэн аливаа үйл ажиллагааны төлөө хариуцлага хүлээхгүй болно.

Мөн тус тайланг боловсруулахад цаг хугацааны боломжгүйгээс дараах хязгаарлагдмал байдлууд үүссэн: материаллаг нөлөөллийн үнэлгээ, өгөгдлийг нягтлах, оролцогч талуудаас мэдээлэл цуглуулах, хэрэглэгчдийн судалгаа зэргийг хийх боломжгүй байсан. Тус БОНЗ-ын тайлантай танилцах эсхүл ашигласнаар та энэхүү мэдэгдэлд дурдсан нөхцөл, хязгаарлагдмал байдлыг хүлээн зөвшөөрч байгаа болно. Хэрэв та энэхүү мэдэгдлийн аль нэг хэсгийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа бол тайланг ашиглахаас татгалзана уу.

Байгууллагын БОНЗ-ын үйл ажиллагаа болон энэхүү мэдэгдлийн талаар нэмэлт мэдээлэл, тодруулга авахыг хүсвэл info@sumongol.mn хаягаар холбогдоно уу.

МЭНДЧИЛГЭЭ



Өлзийсүрэн Эрдэнэчимэг

ТУЗ-ийн хараат бус гишүүн, БОНЗ-ын хорооны дарга

Премиум Нэксус ХК-ийн ажилчид болон удирдлагын багийг төлөөлөн 2023 оны Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын тайланг танилцуулж байгаадаа баяртай байна.

2023 оны эцсээр компанийн хэмжээнд томоохон шилжилтүүд өрнөж, бизнесийн болон үйл ажиллагааны цар хүрээ тэлсэн хэдий ч СУ-ийн бизнесийн стратегийн төвд “Хамтын үнэ цэн”-ийн ойлголт хамгийн чухал хэвээр байна.

Энэхүү хамтын үнэ цэн нь бидний бүхий л үйлдэл, шийдвэр гаргалтад нөлөөлдөг суурь зарчим билээ. Бид уг алсын хараанд хөтлөгдсөөр 2023 онд нийт бараа материалын түгээлтийн 99.9%-ийг нэгдсэн түгээлтийн төвөөр зохион байгуулснаар логистикийн үйл ажиллагаа илүү үр ашигтай, хяналттай болсон. Ингэснээр давхацсан түгээлтийн үйл ажиллагааг байхгүй болгож, түгжрэлийн бус цагаар түгээлтийн үйл ажиллагааг зохион байгуулснаар түгээлтийн тээврийн хэрэгслүүдээс ялгарах нүүрс хүчлийн хийн агаарын бохирдлыг багасгаж чадсан. Дэлгүүрийн тоо 374-т хүрч илүү олон ажлын байрыг бий болгон, нийлүүлэгчдийнхээ бизнесийг өргөжихөд тусалж, Улаанбаатар хотын иргэдэд эрүүл, аюулгүй, чанартай хоол хүнс, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүллээ.

“Хамтын үнэ цэн”-ийн хүрээнд бид шударга, хариуцлагатай, ил тод үйл ажиллагаагаа явуулахыг эрмэлзэн компанийн засаглалаа сайжруулсаар байна. Бид хүмүүс, процесс, тогтолцоондоо хөрөнгө оруулж байгууллагын түвшинд ёс зүйг баримтлан ажилласаар байна. Мөн нийгэмдээ хариуцлагатай компани байх нь бидний нэн тэргүүний зорилго юм. 2023 оны онцлох үйл явдлаас дурдвал СУ хоолны үйлдвэрээс гадна хоол нийлүүлэгч 6 байгууллага НАССР стандартын баталгаажилтыг амжилттай хамгаалан гэрчилгээ авсан. Ирэх оноос бүх хоол нийлүүлэгч нараа НАССР стандартыг хэрэгжүүлэн баталгаажилтын гэрчилгээтэй болгох зорилт тавин ажиллаж байна. Мөн түүнчлэн бид бэлтгэн нийлүүлэгчдэдээ хүнсний аюулгүй байдлын хяналтын тогтолцоо, ёс зүйг хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулсаар байна. Бид 2023 онд бизнесийн цар хүрээгээ тэлэх сонирхолтой жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан “Франчайз хөтөлбөр”-ийг дахин эрчимжүүлж, хүртээмжтэй байдал, тэр дундаа эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор гуравдагч байгууллагуудтай хамтарсан зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлснээр нийт 47 дэлгүүрийн франчайз эрх хүлээн авагч авчээ. СУ конвинеенс сүлжээ дэлгүүрүүд нь шинэ шийдэл, ая тухтай, чанартай үйлчилгээний ахисан стандартыг зах зээлд нэвтрүүлсээр дараагийн жилтэйгээ золгож байна.

Бидний зорилго бол маш энгийн. Монголын хотжиж буй иргэдийн амьдралын чанарыг сайжруулах юм. 2023 онд бид Тогтвортой хөгжлийн 17 зорилгын 10 зорилгод шууд утгаар хувь нэмэр оруулж ажилласан нь үүнийг нэг илрэл билээ.

Улаанбаатар хотын өнцөг булан бүрт манай дэлгүүр байдаг энэхүү дэд бүтэцтээ тулгуурлан бид асуудал, бэрхшээл тулгарахад иргэдийнхээ хамгийн ойр тусламж нь байх зорилгыг тавин ажилладаг. Энэ хүрээнд хүүхэд багачуудыг аюул ослоос хамгаалах, төөрсөн хүүхдүүдийг эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгөх зорилготой ICU хөтөлбөр хэрэгжүүлж, 7 хүүхдийг эцэг эхэд нь эсэн мэнд хүлээлгэн өгсөн. Мөн үерийн гамшиг, идэр есийн хүйтэнд ажиллаж байсан албан хаагчдад халуун хоол, ундаар үйлчилсэн ба цаашид ч бид уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй мөн хүний эрх, нийгмийн аливаа асуудалд өөрсдийн онцлог дэд бүтцэд тулгуурлан туслахад бэлэн байх болно.

Цаашид бид эрсдэлийн удирдлагын хариуцлагатай туршлагаа үргэлжлүүлж, бизнес хийхэд хамгийн үр ашигтай шийдлийг хайж, үйл ажиллагаандаа тогтвортой, нүүрстөрөгчийн ялгаралт багатай туршлагыг хэрэгжүүлэхээр хүмүүс болон үйл ажиллагаандаа хөрөнгө оруулалтыг хийхээр төлөвлөж байна. Бид эх дэлхий, нийгэмдээ эерэг өөрчлөлтийг авчрахаа амлаж байна.

Та бүхнийг тогтвортой хөгжлийн төлөөх бидний хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд нэгдэхийг уриалж байгаадаа таатай байна. Бид хамтдаа байгаль орчин, нийгэмд эерэг нөлөө үзүүлж, “Хамтын үнэ цэн”- ээ нэмэгдүүлж чадна. Үргэлж дэмждэг та бүхэндээ чин сэтгэлээсээ талархаж байна.

ТАНИЛЦУУЛГА

Уг Байгаль орчин, нийгэм, засаглал (цаашид БОНЗ гэх)-ын тайланг Премиум Нэксус ХК-ийн захиалгаар Ризилиенс Консалтинг Сервиз ХХК нь 2024 оны 3 сарын 20-ноос 2024 оны 4 сарын 13-ны өдрийн хугацаанд боловсруулж, хөндлөнгийн үнэлгээ, зөвлөмжийн хамт хийж гүйцэтгэлээ. Компани нь олон нийтэд нээлттэй хувьцаат компани болохын хувьд өөрийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэм, засаглалд үзүүлэх нөлөөллийг Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-ын дагуу ийнхүү гурав дахь жилдээ сайн дурын үндсэн дээр нийт хувьцаа эзэмшигчид, харилцагч, хамтран ажиллагч байгууллагууд олон нийтэд нээлттэй тайлагнаж байна.

Тайланг бэлтгэхдээ Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Монголын тогтвортой санхүүгийн холбоо (ТоС Холбоо), Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК), НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Европын Холбооны Тогтвортой Байдлын Тайлагналын стандарт, Азийн Хөгжлийн банк болон ЕСБХБ-уудын Байгаль орчин, Нийгмийн дью дилиженс, Монголын Хөрөнгийн Биржээс хүлээн зөвшөөрсөн “Байгаль орчин, нийгэм,

засаглал ба тогтвортой байдлын тайлагналын удирдамж”- ийн дагуу болон бусад олон улсын тогтвортой байдлын тайлагналын удирдамжуудыг ашиглан холбогдох дата мэдээллийг цуглуулж, шинжилж, баталгаажуулж, холбогдох зөвлөмжөөр хангасан болно.

Энэхүү БОНЗ ба тогтвортой байдлын тайлан нь Премиум Нэксус ХК, түүний охин компаниуд болох Сэнтрал Фүүдс ХХК, Сэнтрал Коммерс ХХК-ийн 2023 оны үйл ажиллагааг хамарсан бөгөөд шаардлагатай хэсгүүдэд түүхэн дата мэдээллийг оруулсан. БОНЗ ба тогтвортой байдлын тайлангийн хүрээнд дараах асуудлуудын хүрээнд мэдээлэл боловсруулалт хийж уг тайланд оруулав.

БОНЗ ба Тогтвортой байдлын тайланд дараах асуудлуудын хүрээнд мэдээлэл боловсруулалт хийж оруулав.

Зөвлөх багийн зүгээс компани нь ийнхүү ОУ-ын жишигт нийцсэн БОНЗ, тогтвортой байдлын тайланг боловсруулж, оролцогч талуудад нээлттэй мэдээлж буйг сайшаахын зэрэгцээ энэ туршлага нь цаашид улам олон Хөрөнгийн биржид бүртгэлтэй

компаниудыг сайн засаглал, тогтвортой байдлын арга туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд үлгэрлэл болж, МУ-ын тогтвортой хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаа, мөн худалдаа, хүнс үйлдвэрлэлийн салбарт урт хугацааны үнэ цэнийг бий болгоход хувь нэмрээ оруулж байна хэмээн үзэж байна. Цаашлаад БОНЗ, тогтвортой байдлын тайланг жилээс жилд тогтмол баяжуулан олон нийтэд тайлагнаж танилцуулах, БОНЗ-ын илэрсэн үл тохирлуудыг жил ирэх тусам засаж сайжруулснаар салбартаа манлайлахаас гадна дотоод гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх, шууд ба шууд бус үр өгөөж, үнэ цэнийг нийгэмд бий болгох, нэр хүндээ өсгөх боломжоор дүүрэн байгааг дурдах нь зүйтэй.

Тайлангийн уншигчдад болон компанийн оролцогч талуудад уг тайлантай холбоотой нэмэлт тодруулга байвал БОНЗ ба тогтвортой байдлын тайланг боловсруулсан үнэлгээний багтай дараах хаягаар холбогдох боломжтой.

Тогтвортой байдлын удирдлагын тогтолцоо	Байгаль орчин	Нийгэм	Засаглал	Салбарын нэмэлт үзүүлэлт
MS1 Удирдлагын менежмент, амлалт	E1 Эрчим хүч	S1 Хүний нөөцийн хөгжил	G1 Компанийн засаглал	AF1 Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл
MS2 Тогтвортой байдлын бодлого зохицуулалт	E2 Хүлэмжийн хийн ялгарал	S2 Хөдөлмөрийн аюулгүй байдал	G2 Авлига, ёс зүй	MA1 Боловсруулах үйлдвэрлэл
MS3 Удирдлагын бүтэц	E3 Уур амьсгалын өөрчлөлт	S3 Эрх тэгш байдал	G3 Комплаенс, хууль дүрмийн мөрдөлт	
MS4 Тогтвортой хөгжлийн нөлөөллийн үнэлгээ	E4 Ус	S4 Хүртээмжтэй тэгш оролцоо	G4 Оролцогч талуудын оролцоо	
MS5 Чадавч бүрдүүлэлт	E5 Хог хаягдал	S5 Нийгмийн хариуцлага, ил тод байдал		
MS6 Хяналт шинжилгээ	E6 Биологийн олон янз байдал	S6 Тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээний удирдлага		
MS7 Тогтвортой байдлын тайлагнал, баталгаажуулалт				
MS8 Гишүүнчлэл				

АРГАЧЛАЛ

ХОЛБОГДОХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Тайланг бэлтгэхдээ Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Монголын тогтвортой санхүүгийн холбоо (ТоС Холбоо), Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК), НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Европын Холбооны Тогтвортой Байдлын Тайлагналын стандарт, Азийн Хөгжлийн банк болон ЕСБХБ-уудын Байгаль орчин, Нийгмийн дью дилиженс, Монголын Хөрөнгийн Биржээс хүлээн зөвшөөрсөн “Байгаль орчин, нийгэм, засаглал ба тогтвортой байдлын тайлагналын удирдамж”-ийн дагуу болон бусад олон улсын тогтвортой байдлын тайлагналын удирдамжуудыг ашиглан холбогдох дата мэдээллийг цуглуулж, шинжилж, баталгаажуулж, холбогдох зөвлөмжөөр хангасан болно.

МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

Мэдээллийг “Байгаль орчин, нийгэм, засаглал ба тогтвортой байдлын тайлагналын удирдамж”-ийн дагуу болон Олон улсын тайлагналын санаачилга (Global Reporting Initiative)-д дурдсан аргачлалыг лавлагаа болгож, бэлэн тайлагнах боломжтой өгөгдөл мэдээллийн хүрээнд боловсрууллаа. Мөн БОНЗ-ын тайланг боловсруулахад ашигласан, мөн цуглуулах, тайлагнах боломжгүй (n/a тэмдэглэгээтэй) өгөгдөл, мэдээллийг тухай бүрд нь ишлэн бичсэнийг цаашид анхааран бүртгэж, тайлагнадаг болох нь зүйтэй.

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, БАТАЛГААЖУУЛАЛТ

БОНЗ-ын тайланг боловсруулахад Зөвлөх үйлчилгээний багаас гаргасан нийт 249 шалгуур бүхий хяналтын хуудасны дагуу шаардлагатай мэдээллийг захиалагч талаас хүссэний дагуу дараах мэдээллийн эх үүсвэрүүдийг ашиглан үр дүнд боловсруулалт хийн тайланг боловсрууллаа.

- Бичиг баримтын шинжилгээ: Захиалагч Премиум Нэксус ХК, Сэнтрал Фүүдс ХХК-иас бүрдүүлж өгсөн бодлого, журам, мэдээллүүд
- Онлайн дью дилиженс: Цахим орчинд байрлуулсан мэдээлэл, харилцагчид, талуудын гомдол санал

ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ

Мөн тус тайланг боловсруулахад цаг хугацааны боломжгүйгээс дараах хязгаарлагдмал байдлууд үүссэн: материаллаг нөлөөллийн үнэлгээ, өгөгдлийг нягтлах, оролцогч талуудаас мэдээлэл цуглуулах, хэрэглэгчдийн судалгаа зэргийг хийх боломжгүй байсан.

ХУРААНГУЙ

1	Огноо (он, сар, өдөр):	2023 оны 04 сарын 11
2	Үнэт цаас гаргагчийн нэр:	Премиум Нэксус ХК
3	Үнэт цаас гаргагчийн код (МХБ симбол):	CUMN
4	Салбар/үйлдвэрлэл (МХБ-ийн салбарын ангилал):	Худалдаа
5	Тайланд орсон компаниуд (энэхүү тайланд орсон толгой болон охин компаниудын мэдээлэл):	Премиум Нэксус ХК, Сэнтрал Фүүдс ХХК, Сэнтрал Коммерс ХХК
6	Тайлангийн хамрах хугацаа:	2023 оны 1 сарын 1 – 2023 оны 12 сарын 31
7	Хариуцсан албан тушаалтны овог нэр, албан тушаал, холбоо барих имэйл хаяг, утас:	Номуундалай Премиум Нэксус ХК-ийн Хөрөнгө оруулагчдын харилцааны менежер Nomuundalai.ts@premiumcorp.mn Ч.Номинзул, Премиум Нэксус ХК-ийн Санхүүгийн шинжээч Nominzul.ch@cumongol.mn
8	Тайланг баталгаажуулсан Гүйцэтгэх захирал, ТУЗ-ын даргын мэдээлэл (нэр, албан тушаал):	ТУЗ-ын дарга (хараат бус) , ТУЗ-ын дэргэдэх БОНЗ-ын хорооны гишүүн Гари Биондо Gary.b@cumongol.mn

ХУРААНГУЙ: ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГЫН СИСТЕМ

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Премиум Нэксус ХК	Сэнтрал Фүүдс ХК
				Үзүүлэлт, хэмжих нэгж	Үзүүлэлт, хэмжих нэгж
MS	Тогтвортой хөгжлийн удирдлагын тогтолцооны шалгуур үзүүлэлтүүд				
MS1.1	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Удирдлагын амлалт	Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/мэдэгдэл байдаг эсэх	Үгүй	
MS2.1		Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх	Үгүй	
S2.2		Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн журам байдаг эсэх	Үгүй	
MS3.1		Бүтэц удирдлага	Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх	Тийм	
MS3.2		Бүтэц удирдлага	ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм	
MS3.3		Бүтэц удирдлага	Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан менежер (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Үгүй	
MS3.4		Бүтэц удирдлага	Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм	
MS3.5		Бүтэц удирдлага	Танай компани ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тогтмол тусгадаг уу?	Тийм	
MS4.1		Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ	Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, эерэг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн процесс, үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх	Үгүй	

ХУРААНГУЙ: ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГЫН СИСТЕМ

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Премиум Нэксус ХК	Сэнтрал Фүүдс ХК
				Үзүүлэлт, хэмжих нэгж	Үзүүлэлт, хэмжих нэгж
MS	Тогтвортой хөгжлийн удирдлагын тогтолцооны шалгуур үзүүлэлтүүд				
MS5.1		Чадавх бүрдүүлэлт	Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хүйсээр	Үгүй	
MS6.1		Хяналт	Тогтвортой байдлын асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу?	Үгүй	
MS7.1		Тогтвортой байдлын тайлагнал	Танай компани тогтвортой байдал/ хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жил нэгээс доошгүй удаа тайлагнадаг уу?	Тийм	
MS7.2		Тогтвортой байдлын тайлагнал	Танай компани уур амьсгалын эрсдэлийг олон улсын стандарт (УАӨСМТАХ, БОТСМТАХ)-ын дагуу тайлагнадаг уу?	Тийм	
MS7.3		Тогтвортой байдлын тайлагнал	Тогтвортой хөгжлийн болон БОНЗ-ын мэдээллийг хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулдаг уу?	Үгүй	
MS8.1		Гишүүнчлэл, хамтын ажиллагаа	Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу? Үүнд, хүний эрх болон бизнесийн тунхаглал орно.	Тийм	

ХУРААНГУЙ: БАЙГАЛЬ ОРЧИН

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Премиум Нэксус ХК	Сэнтрал Фүүдс ХК
				Үзүүлэлт, хэмжих нэгж	Үзүүлэлт, хэмжих нэгж
E	Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд				
E1.1	Эрчим хүч	Нийт эрчим хүчний хэрэглээ	Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ болон зардал	18,295,628 кВт.цаг	E1.1
E1.2		Цахилгаан	Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	17,282,229 кВт.цаг	E1.2
E1.3		Дулаан	Дулааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	1,013,399 кВт.цаг	E1.3
E1.4		Түлш	Түлшний нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр). Үүнд,	595,6 тн	300 тн нүүрс 120,2 тн түлш 4,4 тн бензин 75,790л газ
			1. Халаах зорилгоор хэрэглэсэн түлш буюу нүүрс, хий	Байхгүй	300 тн нүүрс 75,790л газ
			2. Тээврийн зардалд ашигласан түлш буюу бензин, дизель	Байхгүй	120,2 тн түлш 4,4 тн бензин
E1.5		Хүрэн эрчим хүч	СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувь	100%	
E1.6		Сэргээгдэх эрчим хүч	СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний хэрэглээний хувь	0%	
E2.1	Хүлэмжийн хийн ялгарал	3.1 Хүлэмжийн хийн ялгаруулалт	Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн	20,748 тн CO ₂ eq	
E2.2		3.2 Бууруулсан хүлэмжийн хий	Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийн нийт дүн (жилээр)	10.800 кг CO ₂ eq	
E2.3		3.3 Дүйцүүлэх арга хэмжээ / Карбон офсет/	Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмжийн хийг бууруулах гаднын төслийг дэмжих гэх мэт) бууралт	441.75 кг CO ₂ eq	
E3.1	Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын бодлого, журам	Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу?	Үгүй	
E3.2		Уур амьсгалын эрсдэл ба боломжийн үнэлгээ	Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү? (сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт)	Үгүй	

ХУРААНГУЙ: БАЙГАЛЬ ОРЧИН

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Премиум Нэксус ХК	Сэнтрал Фүүдс ХК
				Үзүүлэлт, хэмжих нэгж	Үзүүлэлт, хэмжих нэгж
E	Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд				
E3.3		Эдийн засгийн хохирол	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ	41,634,482 төг	
E3.4		Уур амьсгалын хөрөнгө оруулалт	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн	Байхгүй	
E3.5		Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх эсвэл дасан зохицох	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/алхмуудыг тодорхойлсон уу?	Үгүй	Үгүй
E4.1	Ус	Усны хэрэглээ	Ашигласан усны нийт хэмжээ	203,674 м3	
E4.2		Хэмнэсэн ус	Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/дахин боловсруулсан усны хэмжээ	Байхгүй	Саарал ус ашигладаггүй
E4.3		Дахин боловсруулсан ус	Дахин ашигласан болон боловсруулсан усны эзлэх хувь	0%	0%

ХУРААНГУЙ: БАЙГАЛЬ ОРЧИН

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Премиум Нэксус ХК	Сэнтрал Фүүдс ХК
				Үзүүлэлт, хэмжих нэгж	Үзүүлэлт, хэмжих нэгж
E	Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд				
E4.4		Хаягдал бохир ус цэвэрлэх	Цэвэрлэсэн нийт хаягдал бохир усны хэмжээ	0%	0%
E5.1	Хатуу хог хаягдал	Хог хаягдал	Нийт ялгаруулсан хог хаягдлын хэмжээ	Тайлагнах боломжгүй (n/a)	
E5.2		Дахин боловсруулсан хатуу хог хаягдал	Хог хаягдлыг дахин боловсруулсан хувь	Байхгүй	3.25 тн хаягдал тос
E5.3		Хортой хог хаягдал	Хортой хог хаягдлын нийт хэмжээ (Үүнд цахилгаан хэрэгслийн хог орно)	Байхгүй	
E6.1	Биологийн олон янз байдал	Ногоон байгууламж, төлөвлөлт	Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт талбайд эзлэх хувь	Тайлагнах боломжгүй (n/a)	13.60%
E6.2		Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах	Хамгаалсан төрөл зүйлийн тоо	Байхгүй	0
E6.3		Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж буй үйл ажиллагаа	Тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, соёлын үнэ цэнэ өндөртэй газар нутгийг эзэмшиж, түрээсэлсэн, удирдаж байгаа эсвэл зэргэлдээх үйл ажиллагааны талбайн нийт талбайд эзлэх хувь	Байхгүй	0%

ХУРААНГУЙ: НИЙГЭМ

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Премиум Нэксус ХК	Сэнтрал Фүүдс ХК
				Үзүүлэлт, хэмжих нэгж	Үзүүлэлт, хэмжих нэгж
S	Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд				
S1.1	Хүний нөөц	Хүний нөөцийн тогтвортой байдал	Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)	66%	72%
S1.2		Шинээр бий болгосон ажлын байр	Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо	890	27
S1.3		Сургалт	Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг	6.5	30.6
S2.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)	ХАБЭА-н бодлого	ХАБЭА-н бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	Тийм
S2.2		Осол аваар	Үйл ажиллагааны явцад гарсан осол аваарын хувь	1.55%	2019 оноос хойш 1 удаа
S2.3		ХАБЭА-н сургалт	Жилд нэг ажилтанд ногдох дундаж ХАБЭА сургалтын цаг	2.08 цаг	97.2
S2.4		Эрүүл мэндийн хөтөлбөр	Эрүүл мэндийн үзлэг зэрэг сайн дурын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилчдын тоо, жилээр	3,106 хүн	Эрүүл мэндийн хугацаат үзлэг 80, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг 391, хеликобактерийн тест 68, дүүргийн эрт илрүүлгийн шинжилгээ 24
S3.1	Эрх тэгш байдал	Жендерийн бодлого, журам	Жендерийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Үгүй	Үгүй
S3.2		Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам	Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	Тийм

ХУРААНГУЙ: НИЙГЭМ

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Премиум Нэксус ХК	Сэнтрал Фүүдс ХК
				Үзүүлэлт, хэмжих нэгж	Үзүүлэлт, хэмжих нэгж
S	Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд				
S3.3		Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	тийм	тийм
S3.4		Ажилтнуудын хүйсийн харьцаа	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь	Эр-24% Эм-76%	эрэгтэй-20%, эмэгтэй 80%
S3.5		Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа	Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр-78% Эм-22%	эрэгтэй-33.3%, эмэгтэй 66.7%
S3.6		Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр-53% Эм-47%	эрэгтэй-75%, эмэгтэй-25%
S3.7		Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр-30% Эм-70%	эрэгтэй-39%, эмэгтэй-61%
S3.8		Жендерт суурилсан цалингийн зөрүү	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа	Эмэгтэй/ Эрэгтэй=1	Эмэгтэй/ Эрэгтэй=1.22
S4.1	Хүртээмжтэй байдал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан олон нийтэд нээлттэй бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	тийм	үгүй
S4.2		Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь	4 %	4 %
S4.3		Оффисын хүртээмж	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн оффис, байгууламжтай юу	үгүй	үгүй
S4.4		Торгууль	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөөгүйн улмаас төлсөн торгуулийн хэмжээ	0	0


ХУРААНГУЙ: НИЙГЭМ

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Премиум Нэксус ХК	Сэнтрал Фүүдс ХК
				Үзүүлэлт, хэмжих нэгж	Үзүүлэлт, хэмжих нэгж
S	Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд				
S5.1	Нийгмийн хариуцлага ба олон нийтийн оролцоо	Оролцогч талуудын оролцооны засаглал	Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу?	тийм	
S5.2		Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого журам	Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журамтай юу? (Үүнд газар чөлөөлөлт багтана)	байхгүй	Байхгүй
S5.3		Санал гомдлыг шийдвэрлэх бодлого/ журам	Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу?	тийм	
S5.4		Олон нийтэд ил тод мэдээлэх	Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу?	тийм	
S5.5		Ажилчид/олон нийтийн санал гомдол	Ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг шийдвэрлэсэн хувь	100%	100%
S5.6		Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт	Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орлогод эзлэх хувь, ТХЗ-оор ангилсан	Энэ чиглэлд оруулсан хөрөнгө оруулалтыг ангилан харсан тоо баримт бэлэн байхгүй байна.	
S6.1	Тогтвортой өртгийн сүлжээний менежмент	Худалдан авалтын бодлого, журам	Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжийг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	
S6.2		Дотоодын худалдан авалт	Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь	97%	90%
S6.3			Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь	байхгүй	

ХУРААНГУЙ: ЗАСАГЛАЛ

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Премиум Нэксус ХК	Сэнтрал Фүүдс ХК
				Үзүүлэлт, хэмжих нэгж	Үзүүлэлт, хэмжих нэгж
G	Засаглал				
G1.1	Компанийн засаглал	Компанийн засаглалын бодлого, журам	Шинээр батлагдсан Кодексийн дагуу компанийн засаглалын бодлого, журам бий юу, уг журмын тайлагнал хийдэг үү?	Тийм	
G1.2		Удирдах зөвлөлийнхараат бус байдал	Удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь	1/3	
G1.3		Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?	Тийм	
G2.1	Авлигал болон ёс зүй	Авлига, хээл хахуулийн эсрэг бодлого журам	Авлигын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу?	Тийм	
G3.1	Комплаенс	Комплаенсын бодлого	Комплаенсын бодлого, журам бий юу?	Тийм	
G3.2		Комплаенсын хөтөлбөр	Комплаенсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу?		
Салбарын онцлогтой нэмэлт шалгуур үзүүлэлтүүд (зөвхөн өөрийн компанид хамаарах салбарын асуултад хариулна)					
AF1	Хөдөө аж ахуй & хүнсний үйлдвэрлэл	Устгалын бодис	Танай компанид хортон шавж устгалын бодисын хэрэглээг зохицуулах бодлого, журам бий юу?	Батлуулах гэж байгаа “Эрүүл ахуйн тухай журам”-д шавьжгүйжүүлэлт, мэрэгчгүйжүүлэлт, халдваргүйжүүлэлтийг тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагаар хийлгэнэ гэж заасан.	Байхгүй
AF3		Буцаан татан авсан бараа бүтээгдэхүүн	Хүнсний чанар, аюулгүй байдлыг хангаагүй буцаагдсан эсвэл худалдах боломжгүй болсон бүтээгдэхүүний хувь	0.035% буюу 103'609'484 төг	Байхгүй

**ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН
УДИРДЛАГЫН
ТОГТОЛЦОО**



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

УДИРДЛАГЫН ҮҮРЭГ АМЛАЛТ

MS1: Удирдлагын амлалт	Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/мэдэгдэл байдаг эсэх	Үгүй
------------------------	----------------------------------------------------------------------	------

Премиум Нэксус ХК нь 2019 оноос Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимд гишүүнээр элсэн орж бизнес эрхлэгчидтэй туршлагаа хуваалцаж, тэднээс суралцаж, B2B платформыг ашиглаж байгаа бөгөөд НҮБ-ын Даян дэлхийн гэрээнд нэгдэн орж Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг бизнесийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, хүний эрхийг хүндэтгэсэн, эх дэлхийн сав шим ертөнцийг хамгаалсан байгаль орчинд ээлтэй, авлига, хээл хахуулиас ангид сайн засаглалыг төлөвшүүлэх чиглэлээр үүрэг амлалт авах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Үүнд:

ХҮНИЙ ЭРХ

Зарчим 1. Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах олон улсын тунхаглалуудыг хүндэтгэх дэмжих;

Зарчим 2. Бизнесийн үйл ажиллагааг хүний эрхийн аливаа зөрчлийн хамтрагч болгохгүй байх;

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Зарчим 3. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хамтын хэлэлцээр байгуулах эрхийг үр ашигтайгаар хүлээн зөвшөөрөх;

Зарчим 4. Хүчээр болон албадан хөдөлмөрлүүлэх аливаа хэлбэрийг арилгах;

Зарчим 5. Хүүхдийн хөдөлмөрийг арилгах;

Зарчим 6. Ажил эрхлэх, албан тушаал хашихад ялгаварлан гадуурхах байдлыг арилгах;

БАЙГАЛЬ ОРЧИН

Зарчим 7. Бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчны аливаа өөрчлөлт доройтлоос урьдчилан сэргийлэх;

Зарчим 8. Бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчны хариуцлагыг өндөржүүлэх;

Зарчим 9. Байгаль орчинд ээлтэй технологийг хөгжүүлэх нэвтрүүлэх;

АВЛИГАЛ

Зарчим 10. Авлигал, хээл хахуулийн бүхэл хэлбэрийн эсрэг тууштай үйл ажиллагаа явуулах.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, СТРАТЕГИ

MS2.1: Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх	Үгүй
MS2.2: Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн журам байдаг эсэх	Үгүй

Хэдийгээр Премиум Нэксус ХК-д тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлсон, хэрэгжилтийг хангасан журмын зохицуулалт хийсэн тухайлсан баримт бичиггүй боловч байгууллагын удирдлагын зүгээс тогтвортой хөгжлийн чиглэлд өгч буй анхаарал зэргийг үндэслэн байгууллагын цаашдын бодлого, стратегид тогтвортой хөгжлийн асуудлуудыг үндсэн асуудлуудын нэгээр тодорхойлж, холбогдох бодлогын баримт бичгийг боловсруулж, удирдлагын түвшинд манлайлал үзүүлэн ажиллаж, компанийн Ёс зүйн дүрмийг шинэчлэн Шүгэл үлээх үйл ажиллагааны журам, Гомдол хүлээж авах, барагдуулах журмыг боловсруулан, хэрэгжүүлж байна. Үйл ажиллагааны зорилго, зорилтоо Тогтвортой хөгжлийн 17 зорилготой уялдуулан тодорхойлон төлөвлөж, хэрэгжилтийг ханган үр дүнг бүх оролцогч талуудад нээлттэй, ил тодоор тайлагнах үйл явц төлөвшин жигдэрсэн байна.

УДИРДЛАГА, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

MS3.1: Бүтэц удирдлага	Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх	Тийм
MS3.2 Бүтэц удирдлага	ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм

Премиум Нэксус ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 2-р сарын 25-ны өдрийн 7 тоот тогтоолоор (“ТУЗ”)-ийн дэргэдэх Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо (“БОНЗ-ын хороо”)-ны үйл ажиллагааны журмыг баталсан бөгөөд БОНЗ-ын хорооны үйл ажиллагааны чиглэл, эрх үүргийн дагуу 3 сар тутам хуралдаж, БОНЗ-ын чиглэлд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар ТУЗ-д жилд хоёроос доошгүй удаа тайлагнах үүрэг хүлээдэг.

БОНЗ-ын Хороо нь гурваас дээш гишүүнтэй байх ба гишүүдийн гуравны хоёр нь заавал хараат бус гишүүн байна. Хорооны гишүүд болон Хорооны даргыг ТУЗ-ийн олонхын саналаар сонгох ба зөвхөн ТУЗ-ийн гишүүн Хорооны гишүүнээр сонгогдох эрхтэй байна. Хараат бус гишүүн хороог удирддаг.

ТУЗ-ийн хорооны нэр	Гишүүдийн нэр	Албан түшаал
Байгаль орчин, нийгэм засаглалын хороо	Ө. Эрдэнэчимэг	Хороон дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн
	Гари Биондо	ТУЗ-ийн дарга (хараат бус)
	З. Уянга	ТУЗ-ийн гишүүн


ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын хороо нь:


- БОНЗ-ын алсын хараа, стратеги, бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэхэд хяналт тавих;
- БОНЗ-ын шинээр гарч ирж буй чиг хандлага, асуудлуудыг хянаж үзэх, үүний дагуу Компанийн БОНЗ-ын талаарх алсын харааг боловсруулах, заавар зөвлөмжийг өгөх;
- Аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах, нийгмийн хариуцлага, компанийн засаглалын талаарх Компанийн бодлогыг тодорхойлох, түүнд шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах;
- ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын сургалт, тасралтгүй мэргэшлийн өсөлтөд хяналт тавих, хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөх бодлого, журам, гарын авлага, ёс зүйн дүрмийг боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг хянах, ТУЗ болон түүний хороодын үйл ажиллагаа, ТУЗ-ийн гишүүдийн оруулсан хувь нэмрийг тогтмол үнэлж, ТУЗ-д зөвлөмж гаргах үүрэгтэй.

MS3.3: Бүтэц удирдлага	Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан менежер (бүтэн цагийн/ хавсран) байдаг эсэх	Тийм
MS3.4: Бүтэц удирдлага	Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм


ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГЫН ЗАГВАР



Нэгдсэн том баг, бага нөөц нь хэлтэс тасагт хуваарилагдсан




Нөөц нь хэлтэс, нэгжид хуваарилагдсан




Дараахь 3 загвар компанид ТХ-н удирдлагын тогтолцоог бүрнээр бүрдүүлэхэд дэмжлэг болно


Нэгдсэн том баг, бага нөөц нь хэлтэс тасагт хуваарилагдсан



Шийдвэр гаргах эрхтэй цөмхөн баг хэлтэс, нэгжийн хүчтэй дэмжлэгтэй



Төвлөрсөн баг, хэлтэс нэгжид мэргэжилтэн ажлуулна



Давуу тал

Байгууллагын түвшинд тогтвортой хөгжлийн асуудлыг илүү хурдан шийдвэрлэх
Төвлөрсөн зорилтыг тодорхойлох төлөвлөх, хянах
Тогтвортой хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийн тууштай, хөндлөнгийн хэлтэс нэгжийн хэрэгжилт

Сул талууд

Төвийн багийн нөөц ихтэй
Хэлтэс, нэгжийн тэргүүлэх чиглэлүүдэд бага хариу үйлдэл үзүүлдэг
Хэлтэс, нэгжүүд нь бизнесийн бусад тогтвортой байдлын санаачлагыг өргөжүүлэх эрхгүй

Давуу тал

Хэлтэс, нэгжийн түвшний хариу илүү хурдан
Эрх бүхий хэлтэс, нэгжүүд нь тодорхой төв удирдамжийг хүлээн авдаг
Төвийн багийн хувьд нөөц бага зарцуулдаг

Сул талууд

Хэлтэс, нэгж доторх илүү хурд, авхаалж самбаа, гэхдээ нийт бизнесийн хүрээнд биш
Хэлтэс, нэгжээс ихээхэн нөөц шаарддаг

Давуу тал

Төвийн баг нь компанийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр, нөөцийг хянадаг
Хөгжиж буй тэргүүлэх зорилтуудыг хангахын тулд нөөцийг уян хатан байршуулдаг
Хэлтэс, нэгжийн дунд шилдэг туршлага, мэдлэгээ хялбархан хуваалцах

Сул талууд

Төвийн багийн хувьд нөөц их шаарддаг
Тогтвортой хөгжлийн бодлого нь дээрээс доошоо чиглэдэг тул хэлтэс, нэгжид санаачлага гаргах эрх мэдэл байдаггүй

Эх сурвалж: McKinsey & Company

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

<p>MS4.1: Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ</p>	<p>Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, эерэг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн процесс, үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх</p>	<p>Тийм</p>
------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-------------

БОНЗ-Н МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Премиум Нэксус ХК-ийн 2023 оны БОНЗ-ын тайлангийн хүрээнд дотоод болон гадаад оролцогч талуудын санал дээр үндэслэн байгууллагын үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчин, нийгэм ба засаглалын нөлөөллийн 14 хүчин зүйлсээр материаллаг байдлын чанарын үнэлгээг хийв.

- Материаллаг байдлын үнэлгээ: БОНЗ-ын аль асуудал нь компани болон түүний оролцогч талуудад хамгийн чухал болохыг тодорхойлохын тулд материаллаг байдлын үнэлгээ хийх бөгөөд энэхүү үнэлгээний ач холбогдол БОНЗ-ын асуудал тус бүр компанийн санхүүгийн гүйцэтгэл, нэр хүнд, урт хугацааны үнэ цэнийг бий болгох чадварт үзүүлэх боломжит нөлөөллийг үнэлэхэд оршдог. Материаллаг байдлын үнэлгээ нь чанарын болон тоон байж болох бөгөөд дотоод болон гадаад оролцогч талуудын хүрээнд хийгддэг.

БОНЗ-ын нөлөөллийн хүрээнд авч үзсэн 14 хүчин зүйлсийн хүрээнд Премиум Нэксус ХК-ийн дэвшүүлсэн зорилтууд болон материаллаг байдлын үнэлгээний матриксыг Зураг 2 ба Хүснэгт 1-т харуулав.



Зураг 2. Материаллаг байдлын үнэлгээний матрикс

Хүснэгт 1, БОНЗ-ын хүрээний зорилтууд

№	Код	Эрсдэлт хүчин зүйлс	Зорилт
1.	Б1	Хүлэмжийн хийн ялгарал	Үйл ажиллагаанаас үүсэх хүлэмжийн хийн ялгарлын Хүрээ 1 (өөрийн үйл ажиллагаанаас) ба Хүрээ 2 (эрчим хүчний хэрэглээнээс шууд эсвэл дам)-нд зорилго дэвшүүлж, бууруулах арга хэмжээ авах.
2.	Б2	Хог хаягдал	Үйл ажиллагаанаас үүсэж буй хатуу болон шингэн хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлэхийг зорих.
3.	Б3	Эрчим хүчний хэрэглээ	Цахилгаан, дулааны хэмнэлттэй технологи, тоолуурыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, сурталчлах замаар уур амьсгалын өөрчлөлтийг хязгаарлахад хувь нэмэр оруулахыг зорих.
4.	Б4	Усны хэрэглээ	Ахуй, ундны усыг ариг гамтай хэрэглэх, тоолууржуулах, ус алдагдлыг багасгах санаачилга, соён гэгээрүүлэх арга хэмжээ авч ажиллах.
5.	Н1	Хүний эрх	Хүний эрхийг хүндэтгэсэн, хариуцлагатай, хүртээмжтэй, ая тухтай үйлчилгээг эрхэмлэн хүний эрхийн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил үүссэн бол түүнийг бууруулах, арилгах, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх цогц тогтолцоог хэрэгжүүлэх.
6.	Н2	Нийгмийн хариуцлага	Нийгмийн салшгүй нэг хэсэг гэдгээ хүлээн зөвшөөрч хүн ба байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа эрхлэхийг чармайх.
7.	Н3	Хөдөлмөрийн харилцаа	Ажилтан бүрд хөдөлмөрөө шударгаар үнэлүүлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, эвлэлдэн нэгдэх, сурч хөгжих боломжийг олгох.
8.	Н4	Хүнсний аюулгүй байдал	Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал, хяналтын тогтолцоог төлөвшүүлэн ажиллах.
9.	Н5	ХАБЭА	Ажилтны эрүүл мэндийг хамгаалах, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөл бүхий хүнд ээлтэй ажлыг байрны соёлыг хэвшүүлэх.
10.	Н6	Тогтвортой худалдан авалт	Тогтвортой (ногоон) ханган нийлүүлэгчийн бодлогоор дамжуулж харилцагч, нийлүүлэгчдэд үйл ажиллагаандаа хаягдлыг бууруулах, хүний эрхийг дээдэлсэн хариуцлагатай нөөцийг зохистой ашиглаж, орон нутгийн бизнесийг дэмжин хөгжүүлэх, хүнд ээлтэй ажлыг байр бүрдүүлэх чиглэлээр нөлөөлөн хамтран ажиллах.
11.	31	Ёс зүй	Бизнесийн ёс зүйн зарчмыг чандлан сахих.
12.	32	Бизнесийн тасралтгүй байдал	Болзошгүй өөрчлөлт, хямралын эрсдэл, үр дагаврыг урьдчилан үнэлж, төлөвлөж, хэрэгжүүлэх замаар бизнесийн тасралтгүй үйл ажиллагааг хангах.
13.	33	Мэдээллийн ил тод байдал	Мэдээллийн хоёр чиглэлийн урсгалыг эрхэмлэн, бизнесийн үйл ажиллагааны тайлан, мэдээг нээлттэй ил тодоор оролцогч талуудад хүргэх.
14.	34	Ялгаатай байдал, Тэгш боломж, Оролцоо	Байгууллагын менежментийн бүх шатанд жендерийн эрх тэгш байдлыг ханган ажиллахыг чармайх.

ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тогтвортой хөгжлийн сургалтын нэгдсэн хөтөлбөр гараагүй боловч Хөдөлмөрийн харилцаа, ХАБЭА, байгаль орчин, бэлтгэн нийлүүлэлтийн тогтвортой байдал чиглэлээр сэдэвчилсэн сургалтууд хийгдсэн. Мэдээллүүд нь холбогдох хэсэгт орсон болно.

MS5.1: Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хүйсээр	Цаг	0.00
--------------------------------------------------------------------------------------------------	-----	------

ТАЙЛАГНАЛ БА БАТАЛГААЖУУЛАЛТ

Премиум Нэксус ХК нь 2021 оноос эхлэн (олон нийтэд нээлттэй хувьцаат компани болохоосоо өмнө) БОНЗ-ын тайланг боловсруулж, хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулж, олон нийтэд нээлттэй байршуулж байна. 2022 оны тайлантай энд дарж танилцана уу.

MS7.1: Танай компани тогтвортой байдал/ хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жил нэгээс доошгүй удаа тайлагнадаг уу?	Үгүй
MS7.2: Танай компани уур амьсгалын эрсдэлийг олон улсын стандарт (УАӨСМТАХ, БОТСМТАХ)-ын дагуу тайлагнадаг уу?	Үгүй

ХЯНАЛТ

ТУЗ-ийн дэргэдэх “БОНЗ-ын хороо” нь компанийн БОНЗ-тай холбоотой бодлого, стратеги болон дүрэм журмыг боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг хянан нягтлах үүрэгтэй ажилладаг тул Аудитын хорооны чиг үүрэгт тогтвортой байдлын асуудал хамаардаггүй.

MS6.1: Тогтвортой байдлын асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу?	Үгүй
---------------------------------------------------------------------------------------------------------------------	------

ГИШҮҮНЧЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА


Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран ажилладаг. НҮБ-н Бизнес ба Хүний Эрхийн чиглэлээр баримтлах зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд төр болон олон улсын байгууллагаас хөхиүлэн дэмжиж буйд хамтын чармайлтаар ТХ-н зорилго, зорилтуудыг биелүүлэхэд идэвхтэй оролцож байна.

MS8.1: Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу? Үүнд, хүний эрх болон бизнесийн тунхаглал орно.	Үгүй
-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------

БАЙГАЛЬ ОРЧИН

Монгол улсын Байгаль хамгаалах хууль, Байгаль орчны үнэлгээний тухайн хуулийн хүрээнд Сэнтрал Фүүдс ХХК нь Байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэж, жил бүр байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөг эрх бүхий байгууллагаар батлуулан хэрэгжилтийн хангаж ажиллаж байна. Мөн 2023 онд салбар дэлгүүрүүдийн хувьд Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлтийн хүрээнд байгаль хамгаалах, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлж байна.

1. Эрчим хүчний хэрэглээ
2. Хүлэмжийн хийн ялгарал
3. Уур амьсгалын эрсдэл
4. Усны хэрэглээ
5. Хог хаягдал
6. Биологийн олон янз байдал



ЭРЧИМ ХҮЧ

Премиум Нэксус ХК болон Сэнтрал Фүүдс ХХК нь өөрийн оффисоос гадна 375 конвинеенс салбар дэлгүүр, хоолны үйлдвэр, түүний дэргэдэх хүйтэн хэлхээт түгээлтийн төв, мөн хэвийн температурын горимтой бүтээгдэхүүн түгээлтийн төв гэсэн объектуудад үйл ажиллагаа явуулдаг бөгөөд объектууд бүгд Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК-тэй эрчим хүчээр хангуулах тухай гэрээ хийн төлбөрийг хугацаанд барагдуулж ажилладаг.

Тайлант жилд үйл ажиллагаандаа 18,295,628 кВт.ц-ийн эрчим хүч хэрэглэсэн бөгөөд үүнээс 17,282,229 кВт.ц нь цахилгаан, 1,1013,399 кВт.ц нь дулаан байна. 2022 онтой харьцуулахад 2023 оны цахилгааны хэрэглээ 42,6 %-иар нэмэгдсэн нь дэлгүүрийн тоо өмнөх оноос 101-р нэмэгдсэнтэй холбоотой. Нийт цахилгааны хэрэглээний ихэнх хувийг сүлжээ дэлгүүрүүд, эзэлж байна.

Эрчим хүчний хэрэглээ, кв.ц




График 1. Эрчим хүчний хэрэглээ

Эрчим хүчний үзүүлэлтүүд	Үзүүлэлт, хэмжих нэгж	Жил	Нийт дүн /кВт.цаг/	Жилийн дундаж дэлгүүр	Нэг дэлгүүрт ноогдох	Системийн борлуулалт / төг/	Системийн борлуулалт / Эрчим хүч-ий харьцаа
E 1.1 Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ болон зардал	кВт цаг	2019	3,819,150	38	100,504	41,214,800,000	10,792
		2020	5,091,701	77	66,126	49,882,800,000	9,797
		2021	3,664,600	118	31,056	106,689,976,359	29,114
		2022	12,825,458	222	57,772	293,572,875,314	22,890
		2023	18,295,628	323	56,643	432,250,702,593	23,626
E 1.2 Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	кВт цаг	2019	3,347,068	38	88,081	41,214,800,000	12,314
		2020	4,712,985	77	61,208	49,882,800,000	10,584
		2021	3,583,567	118	30,369	106,689,976,359	29,772
		2022	11,750,119	222	52,928	293,572,875,314	24,985
		2023	17,282,229	323	53,505	432,250,702,593	25,011
E1.3 Дулааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	кВт цаг	2019	472,082	38	12,423	41,214,800,000	87,304
		2020	378,716	77	4,918	49,882,800,000	131,716
		2021	81,033	118	687	106,689,976,359	1,316,619
		2022	1,075,339	222	4,844	293,572,875,314	273,005
		2023	1,013,399	323	3,137	432,250,702,593	426,536

Хоолны үйлдвэрт хөргүүрүүд цахилгааны тэжээлээр шийдэгдсэн, тоног төхөөрөмжүүдийг газар, дулаанаа нам даралтын зуухаар шийдсэн. Нам даралтын зуух тортог баригчтай, сайжруулсан түлш түлдэг. Цахилгаан тасрах, газын хоолой бөглөрөх зэрэг нэмэлт эрчим хүчний үүсгүүр шаардлагатай тохиолдолд түрээсийн дизель генератор ажиллуулан хөлдөхөөс сэргийлсэн. Дизель генератор нь өөрийн нөөцийн савтай, агаарын фильтертэй учир яндангаас агаар бохирдуулагч бодисууд ялгаруулдаггүй.

2023 онд 10м³ хийн түлш хадгалах сав, 500л-ын дундын сав бүрэн автомат газан хийн байгууламжийн системийг ашиглалтад оруулсан. Ингэснээр үйлдвэрийн цахилгаан зарцуулалтыг бууруулж нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулсан.

Эрчим хүчний үзүүлэлтүүд	Эрчим хүчний хэрэглээ (жилээр)	Эрчим хүчний зардал, ₮
E 1.4: Түлшний нийт зарцуулалтын хэмжээ	595.6тн түлш 300 тн сайжруулсан нүүрс 75,790 л газ	515,968,815
1. Халаах зорилгоор хэрэглэсэн түлш буюу нүүрс, хий	300 тн сайжруулсан нүүрс 75,790 л газ	51,290,137 177,385,500
2. Тээврийн зардалд ашигласан түлш буюу бензин, дизель	596.4тн дизель	287,294,178
E 1.5: Хүрэн буюу СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувь	100%	
E 1.6: СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний хэрэглээний хувь	0%	

ЭРЧИМШИЛ

Нийт эрчим хүчний хэрэглээний салбар дэлгүүрүүд эзэлж байгаа эрчимшлийг тооцож үзвэл дэлгүүрт 1 хэрэглэгчид үйлчлэхэд 2.62 кВт.ц зарцуулдаг, 1 сая төгрөгийн борлуулалт тутамд 39.98 кВт.ц эрчим хүч зарцуулдаг бөгөөд анхны суурь жил болох 2019 онтой харьцуулахад 1 хэрэглэгчид үйлчлэхэд ашигладаг байсан эрчим хүчний хэмжээ 1.45 дахин ихэссэн, 1 сая төгрөгийн борлуулалт хийхэд зарцуулдаг эрчим хүч 49.2 дахин буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь компанийн борлуулалтын орлого тутам дахь эрчим хүчний хэрэглээний үр ашиг нэмэгдэж байгаа, мөн нэг хэрэглэгч нэг бүтээгдэхүүн биш олон төрлийн бүтээгдэхүүн худалдан авдаг болохыг харуулж байна.




График 2. Эрчимшил

ТҮЛШ БАГА ЗАРЦУУЛДАГ, АГААРЫН БОХИРДОЛ БАГАТАЙ ТЭЭВЭР

Премиум Нэксус ХК нь түгээлтээ гэрээт компаниар гүйцэтгүүлдэг бөгөөд бүх хүргэлтийн үйлчилгээ өглөөний 4-8 цагийн хооронд хоол ханган нийлүүлэгч үйлдвэрүүд, хөлдөөсөн импортын хүнс нийлүүлэгчид хотын зүүн захад байрлах хүйтэн хэлхээт түгээлтийн төв рүү, түгээлтийн төвөөс салбар дэлгүүрүүд рүү 39 ш хүйтэн хөргүүрт машинаар өдөрт 200 гаран нэр төрлийн 80,000 – 100,000 хоолыг, энгийн горимт хүнс нийлүүлэгчид хотын баруун урд захад байрлах түгээлтийн төв рүү, түгээлтийн төвөөс салбар дэлгүүрүүд рүү 29 ш энгийн ачааны машинаар тус тус тээвэрлэдэг.

Хүйтэн хэлхээний түгээлтийн дэд бүтцийг байгуулснаар 400 гаруй үйлдвэрлэгч, бэлтгэн нийлүүлэгчдийн бүтээгдэхүүний түгээлтийг төвлөрүүлэн, 6,600,000 орчим зорчих хөдөлгөөнийг 132,000 болтол бууруулж нийслэл хотын замын хөдөлгөөний ачааллыг бууруулахад хувь нэмрээ орууллаа. Ингэснээр энгийн үетэй харьцуулахад агаарын бохирдлыг 98% бууруулж буй арга хэмжээг нэвтрүүлэхэд зарцуулсан 15 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт болжээ.

Түгжрэлгүй үед түгээлт хийснээр 4 дахин цаг хэмнэхээс гадна шатахуун зарцуулалтыг 80%-аар бууруулдаг (Трэйбэр нар, 2007). Илүү бага дизель зарцуулахаас гадна түгжрэлд удаан зогсохгүй, тогтмол хурдаар явж байгаа учир хэмнэсэн хугацааны турш ялгарах байсан дизелийн утаанаас сэргийлж агаарын бохирдол, хүлэмжийн хийн ялгарлыг тэр хэрээр бууруулж байна.



ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ

Тайлант хугацаанд өөрийн үйл ажиллагаанаас үүсэх хүлэмжийн хийн ялгарах (1-р хүрээний) болон өөрийн үйл ажиллагаанд гаднаас худалдан авч байгаа хэрэглээний эрчим хүчний (2-р хүрээний) хүлэмжийн хийг бэлэн байгаа өгөгдлүүд дээр үндэслэн тооцлоо. Хүлэмжийн хийн шууд бус (3-р хүрээний) ялгарлыг тооцоход мэдээлэл дутуу тул энэ удаагийн тайланд мэдээллийг оруулсангүй. 1-р хүрээний хүлэмжийн хийн тооцоололд өөрийн үйл ажиллагаа буюу зэрэг мэдээллийг оролцуулан тооцоог хийсэн. Үүнд зарж борлуулж буй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх ба хаягдлыг боловсруулахад гарч буй хүлэмжийн хийн ялгарал, бусад тээвэр, болон хаягдлын задаргааны мэдээлэл байхгүй учир тооцоогүй болно. Мөн бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон борлуулалтын үйлчилгээний LCA буюу Амьдралын мөчлөгийн үнэлгээ хийгдээгүй тул нарийвчлан тооцохгүй боломжгүй юм.

Хүлэмжийн хийн тооцооллоос дүгнэхэд гаднаас худалдан авч буй эрчим хүчний хэрэглээнээс үүсэх 2-р хүрээний хүлэмжийн хийн ялгарал өндөр байна.

Е 2.1: Хүлэмжийн хийн ялгаруулалт	Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн. Үүнээс:	20,594,12 тн CO _{2eq}
	1-р хүрээний (Шууд)	2,830 тн CO _{2eq}
	2-р хүрээний (Шууд бус эрчим хүч)	17,929.71 тн CO _{2eq}
Е 2.2: Бууруулсан хүлэмжийн хий	Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас бууруулсан хүлэмжийн хийн нийт дүн (жилээр)	10,800 кг CO _{2eq}
Е 2.3: Дүйцүүлэх арга хэмжээ / Карбон офсет/	Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмжийн хийг бууруулах гаднын төслийг дэмжих гэх мэт) бууралт	441.75 кг CO _{2e}

ТООЦООНД ОРСОН ӨГӨГДӨЛ	ЦУГЛУУЛАХ, ТООЦООНД ОРУУЛАХ БОЛОМЖГҮЙ МЭДЭЭЛЭЛ
<p>2-Р ХҮРЭЭ: Эрчим хүчний хэрэглээ:</p> <ul style="list-style-type: none"> Хоолны үйлдвэрт ашиглаж буй Газ, нүүрс, дизель <p>Түлшний хэрэглээ:</p> <ul style="list-style-type: none"> Ажилтнуудын нэгдсэн автобус. Томилолтоор гадаад, дотоодод аялсан тээвэр, <p>2-Р ХҮРЭЭ: Эрчим хүчний хэрэглээ:</p> <ul style="list-style-type: none"> 375 дэлгүүр, 1 хоолны үйлдвэр, 2 түгээлтийн төв <p>Түлшний хэрэглээ:</p> <ul style="list-style-type: none"> Түгээлтийн машин 	<p>1-Р ХҮРЭЭ:</p> <ul style="list-style-type: none"> Үйл ажиллагаанаас санаатай болон санамсаргүй ялгарч буй бусад. <p>3-Р ХҮРЭЭ:</p> <ul style="list-style-type: none"> Ландфилд хаясан нийт хаягдал. Зарж борлуулж буй импортын барааны үйлдвэрлэл, Үйлдвэрлэл, үйл ажиллагаанаас ялгарсан хүнсний болон бусад хог хаягдал, нарийвчилсан ангиллаараа (органик, ахуйн, хуванцар, шил, цаас г.м.), Зарж борлуулсан бүтээгдэхүүний хаягдал (ангиллаараа), түүний боловсруулалт, Тооцоонд ороогүй бусад тээвэр.

Хүснэгт 3. Хүлэмжийн хийн хамрах хүрээ

Өмнөх жилүүдийн өгөгдөл, хүлэмжийн хийн тооцоолол хийгдсэн суурь жил байхгүй учир хүлэмжийн хий бууруулах арга хэмжээ авсан хэдий ч тухайн бууралтыг хэмжиж, тооцоолох боломжгүй байна.

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ

Нийслэлийн Захирагчийн Ажлын Албанаас зохион байгуулж буй “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцэгжүүлэх” ажлыг Премиум Нэксус ХК нь дэмжин ажиллаж ногоон байгууламжгүй сүлжээ дэлгүүрийн 43 салбарыг хамруулж 75 ширхэг бортоготой цэцэглэдэг мод болон гоёлын цэцгийг тарьснаар 441.75 кгCO_{2e} хүлэмжийн хийг бууруулах түүнийг шингээлтийг бий болгох үр дүнтэй ажил болжээ. Мөн байгальд ээлтэй шингэдэг кофены аягыг хэрэглээ тайлант хугацаанд 540,000 ш ашигласан бөгөөд энэхүү аягыг бусад нийтлэг хэрэглэдэг кофены аягатай харьцуулахад 10,800 кгCO_{2e} хэмжээгээр хүлэмжийн хийг багасгасан байна.

ЭРЧИМШИЛ

Нийт хүлэмжийн хийн эрчимшлийг тооцож үзвэл 1 хэрэглэгчид үйлчлэхэд 2.19 кгCO_{2e}, 1,000,000 төгрөгийн борлуулалт бүрд 20.98 кгCO_{2e} ялгаруулж байна.

	Зарцуулалт	Хүлэмжийн хийн ялгарал, тн CO _{2e}	Хүрээ
1	Эрчим хүч		
	Цахилгаан	16,936,58	2
	Дулаан	993.13	2
	Сайжруулсан нүүрс (лигнит)	726	1
	Газ (LPG)	208.4	1
	Нийт	18,864.11	
2	Тээвэр		
	Түгээлтийн машин	1,894	1
	Ажилчдын тээвэр		1
	Нийт	1,894	
	Нийт ялгаруулсан хэмжээ	207581.11	
3	Шингээлт хийсэн арга хэмжээ		3
	Кофены аяга	10,8	3
	Тарьсан мод	0.45	offset
	Нийт шингээлт хийсэн хэмжээ	11.25	
	НИЙТ ЯЛГАРУУЛАЛТ	20,748	1, 2, 3

Хүснэгт 3. Хүлэмжийн хийн хамрах хүрээ

УУР АМЬСГАЛЫН ЭРСДЭЛ

Е 3.1: Уур амьсгалын бодлого, журам	Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу?	Үгүй
Е 3.2: Уур амьсгалын эрсдэл ба боломжийн үнэлгээ	Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү? (сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт)	Үгүй
Е 3.3: Эдийн засгийн хохирол	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ	n/a
Е 3.4: Уур амьсгалын хөрөнгө оруулалт	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн	n/a
Е 3.5: Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх эсвэл дасан зохицох	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/алхмуудыг тодорхойлсон уу?	Үгүй

УС

Е 4.1: Усны хэрэглээ	Ашигласан усны нийт хэмжээ	203,674 м3
	Үүнээс Премиум Нэксус:	173,642 м3
	Үүнээс Сэнтрал Фүүдс:	30,032 м3
Е 4.2: Хэмнэсэн ус	Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/дахин боловсруулсан усны хэмжээ	n/a
Е 4.3: Дахин боловсруулсан ус	Дахин ашигласан болон боловсруулсан усны эзлэх хувь	0%
Е 4.4: Хаягдал бохир ус цэвэрлэх	Цэвэрлэсэн нийт хаягдал бохир усны хэмжээ	n/a

УСАН ХАНГАМЖ

Төвлөрсөн цэвэр, бохирын системд холбогдоогүй цөөн хэдэн СУ дэлгүүрүүд хотын захаар байрлах бөгөөд зөөврийн усан хангамжаар шийдсэн байдаг. Хүнсний үйлдвэр мөн зөөврөөр усаа шийдсэн бөгөөд цэвэр, бохир төвийн шугамтай холбогдох зорилгоор дэд бүтцээ байгуулсан бөгөөд 10 тонны хэмжээтэй усны танктай. Хоолны үйлдвэрт ашиглагдах ус 4 төрлийн мембран фильтрээр физик, хими, микробиологийн цэвэршүүлэлт хийгдэн ашиглагддаг, фильтрийг жилдээ нэг сольдог. Усны чанарыг Эрүүл ахуйн журмын дагуу улирал бүр холбогдох байгууллагаар шинжилгээнд хамруулдаг. Үйлдвэрээс гарах хаягдал ус бохирын төвлөрсөн шугамд нийлүүлэгддэг.

УСНЫ ХЭРЭГЛЭЭ

Салбар дэлгүүрүүдийн хувьд цэвэр усны хэрэглээ нь халуун цай болон бусад найруулдаг уух зүйлс бэлтгэх, цэвэрлэгээ хийх, болон ариун цэврийн өрөөний хэрэглээнээс бүрдэнэ. Салбар дэлгүүрүүдэд ух хэмнэх мэдрэгчтэй угаалтуур болон суултуурын усны таталтыг 50%-р бууруулсан арга хэмжээ авсан.

Хоол үйлдвэрлэлийн усны хэрэглээ нь хоол үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, ахуйн хэрэглээ, лабораторийн цэвэрлэгээ гэсэн гол зориулалтаар хэрэглэнэ. Усны хэрэглээний эрчимшлийг График 4.-оос харвал нэг сая төг тутам усны хэрэглээ 2.5 дахин багассан байна.

Дэлгүүрүүд цэвэрлэгээгээ ээлж солигдоход буюу ажлын цагийн хуваариас хамааран 2-3 удаа цэвэрлэдэг бөгөөд эрүүл ахуйн чанарын шаардлага хангасан цэвэрлэгээний бодисыг стандарт ажиллагааны зааврын дагуу ашигладаг. Үйлдвэрийн хувьд өдөртөө нэг тогтмол цэвэрлэгээг хийдэг бөгөөд мэргэжлийн цэвэрлэгээний байгууллагаар улиралдаа нэг их цэвэрлэгээ хийлгэдэг.

Усны хэрэглээний эрчимшил




График 4. Нэг дэлгүүрийн усны хэрэглээ

Үзүүлэлт, хэмжих нэгж	Нийт дүн	Жилийн дундаж дэлгүүр	Нэг дэлгүүрт ноогдох	Системийн борлуулалт	Усны хэрэглээболон борлуулалтын харьцаа
2019	5,578.07	38.00	146.79	41,214,800,000	7,388,720
2020	28,289.36	77.00	367.39	49,882,800,000	1,763,306
2021	47,567.61	118.00	403.12	106,689,976,359	2,242,912
2022	3,459.30	222.00	285.85	293,572,875,314	4,626,160
2023	03,674.00	323.00	630.57	432,250,702,593	2,122,267

Хүснэгт 5. Усны хэрэглээний нэгдсэн хүснэгт

ХОГ ХАЯГДАЛ

Бүх объект харьяа дүүргийн холбогдох тохижилт үйлчилгээний төрийн компаниудтай гэрээлсэн бөгөөд зарим CU дэлгүүрүүдийн хувьд түрээслэгч хаягдлыг хариуцдаг.

E5.1: Хог хаягдал	Нийт ялгаруулсан хог хаягдлын хэмжээ	n/a
E5.2: Дахин боловсруулсан хатуу хог хаягдал	Хатуу хог хаягдлыг дахин боловсруулсан хувь	3.25 тн
E5.3: Хортой хог хаягдал	Хортой хог хаягдлын нийт хэмжээ (Үүнд цахилгаан хэрэгслийн хог орно)	n/a

САЛБАР ДЭЛГҮҮР:

CU конвениенс дэлгүүрийн концепц нь хог хаягдал ангилан ялгалт, дахин боловсруулах арга аргачлалыг шаардсан дэд бүтцэд тулгуурлан хөгжүүлсэн үйлчилгээ бөгөөд хог хаягдлын менежмент хөгжил султай манай орны нөхцөлд өөр түвшний, маш тодорхой менежментийн үйл ажиллагааг шаардаж байна. Иймээс нэн тэргүүнд анхаарал өгч ажиллах шаардлагатай хүрээлэн буй орчны бүрдэл зүйл бол хог хаягдлын асуудал юм. Салбар дэлгүүрээс ялгарах хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгадаггүй бөгөөд дэлгүүрт шингэн болон хуурай гэсэн хогийн савууд байршуулсан байдаг.

Салбар дэлгүүрийн хог хаягдлын хэмжээг нарийн хэмждэггүй. Цөөн салбаруудын хэрэгжүүлж буй дахин боловсруулах арга хэмжээг албан ёсоор бүртгэдэггүй учир энэхүү тоог гаргаж баталгаажуулах шаардлагатай. Түүнчлэн хаягдлын бүтцийг ангилж, хэдэн хувь нь дахин боловсруулагдах боломжтой гэдгийг тодорхойлсноор хог хаягдлын менежментийг хийх боломжтой болох юм.

ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ

Хоол үйлдвэрлэлийн хувьд үйл ажиллагаанаас гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, эх үүсвэр дээр нь ангилан ялгах, дахин боловсруулах цогц тогтолцоог нэвтрүүлсэн. Бүх дэлгүүрүүдэд хогийг төрөлжүүлэн ангилах стандартын шаардлага хангасан сав байрлуулж, үйлдвэрийн хоолны хаягдлыг гахайны фирмд, ашигласан тосыг савангийн үйлдвэрт, цаасан хайрцаг рулоныг дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлж, ландфилд зайлуулагдах хогийг тухайн дүүргүүдийн Тохижилт үйлчилгээний төвүүдтэй байгуулсан гэрээний дагуу 7 хоног тутам ачуулж, орчны ариутгал халдваргүйжүүлэлт хийж хэвшсэн.

Цаасан хайрцаг	Цаасан хайрцаг авдаг хувь хүн, компанитай холбогдох, гэрээ байгуулж тогтмол ачдаг хуваарьтай болох	Хаягдал цаасан хайрцаг цуглуулдаг иргэнтэй холбогдсон цаашид 1 удаагийн ачилт хэдэн төгрөг байх тал дээр ярилцаж байгаа. Одоогийн байдлаар туршилтаар Түгээлтийн төвөөс үнэгүй ачиж байгаа.
Гялгар уут / Рулон/	Хувь хүн, гэрээ байгуулан хаягдал гялгараа тодорхой үнээр худалдах эргээд тухайн орлогоороо ногоон байгууламж, тохижилт хийх	Мултипак ХХК хаягдал рулон цуглуулан дахин боловсруулж рулон үйлдвэрлэдэг компанитай холбогдсон бөгөөд тухайн компанид хаягдал рулоноо өгөн төлбөрт нь дахин боловсруулсан рулоноор зөрүү хийн ашиглах болно.
Кофены аяга	Байгальд ээлтэй шингэдэг кофены аягыг хэрэглэдэг	Нийт тайлант хугацаанд 540,000 ш аягыг ашигласан байна.

ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ

Хоол үйлдвэрлэлийн хувьд үйл ажиллагаанаас гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, эх үүсвэр дээр нь ангилан ялгах, дахин боловсруулах цогц тогтолцоог нэвтрүүлсэн. Бүх дэлгүүрүүдэд хогийг төрөлжүүлэн ангилах стандартын шаардлага хангасан сав байрлуулж, үйлдвэрийн хоолны хаягдлыг гахайны фирмд, ашигласан тосыг савангийн үйлдвэрт, цаасан

хайрцаг рулоныг дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлж, ландфилд зайлуулагдах хогийг тухайн дүүргүүдийн Тохижилт үйлчилгээний төвүүдтэй байгуулсан гэрээний дагуу 7 хоног тутам ачуулж, орчны ариутгал халдваргүйжүүлэлт хийж хэвшсэн.

Цаасан хайрцаг	Цаасан хайрцаг авдаг хувь хүн, компанитай холбогдох, гэрээ байгуулж тогтмол ачдаг хуваарьтай болох	Хаягдал цаасан хайрцаг цуглуулдаг иргэнтэй холбогдсон цаашид 1 удаагийн ачилт хэдэн төгрөг байх тал дээр ярилцаж байгаа. Одоогийн байдлаар туршилтаар Түгээлтийн төвөөс үнэгүй ачиж байгаа.
Гялгар уут /Рулон/	Хувь хүн, гэрээ байгуулан хаягдал гялгараа тодорхой үнээр худалдах эргээд тухайн орлогоороо ногоон байгууламж, тохижилт хийх	Мултипак ХХК хаягдал рулон цуглуулан дахин боловсруулж рулон үйлдвэрлэдэг компанитай холбогдсон бөгөөд тухайн компанид хаягдал рулоноо өгөн төлбөрт нь дахин боловсруулсан рулоноор зөрүү хийн ашиглах болно.
Кофены аяга	Байгальд ээлтэй шингэдэг кофены аягыг хэрэглэдэг	Нийт тайлант хугацаанд 540,000 ш аягыг ашигласан байна.

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ


Тайлант хугацаанд 43 СИ конвениенс дэлгүүрүүд гадна талдаа ногоон байгууламж үүсгэн 75 мод болон цэцэгт мандлыг бий болгосон байна. Хоолны үйлдвэрийн хувьд өөрийн талбайн 13.6%-д ногоон байгууламж тарьсан байна.

Салбар дэлгүүрүүд болон Хоол үйлдвэрлэлийн хувьд хүн амын суурьшлын бүсэд байрладаг тул дуу чимээ, агаар, хөрсний бохирдлыг бий болгодоггүй тул биологийн олон янз байдалд үзүүлэх сөрөг нөлөөлөл багатай байна.

Е 6.1: Ногоон байгууламж, төлөвлөлт	Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт талбайд эзлэх хувь	n/a
Е 6.2: Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах	Хамгаалсан зэрлэг ургамал, амьтдын төрөл зүйлийн тоо	n/a
Е 6.3: Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж буй үйл ажиллагаа	Тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, соёлын үнэ цэнэ өндөртэй газар нутгийг эзэмшиж, түрээсэлсэн, удирдаж байгаа эсвэл зэргэлдээх үйл ажиллагааны талбайн нийт талбайд эзлэх хувь	n/a

НИЙГМИЙН ҮНЭЛГЭЭ

1. Хүний нөөц, жендерийн эрх тэгш байдал
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
3. Нийгмийн хариуцлага, ил тод байдал
4. Тогтвортой өртгийн сүлжээний менежмент



ХҮНИЙ НӨӨЦ, ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ

CU брэнд салбар дэлгүүрийн тоогоо жилээс жилд нэмэгдүүлэхийн хэрээр ажлын байр шинээр бий болдог (График 5). 2023 онд салбар дэлгүүрийн тоо 89-өөр нэмэгдэж 374 болсон. Үүнийг дагаад 890 ажлын байр шинээр бий болсон. Насны бүтцийг авч үзвэл компанийн ажилтны дийлэнх олонх нь 18-34 насны залуучууд байна. Тэр дундаа олон тооны оюутны дэлгүүрт цагийн ажилтан хийдэг. Монгол Улсад “цагийн ажил” гэх ойлголтыг нутагшуулж, өдгөө ажилтнуудын 50 гаруй хувийг цагийн ажилтнууд буюу дийлэнхийг оюутан залуус эзэлж байна. Оюутан залууст хичээлийнхээ хажуугаар тогтмол орлоготой, уян хатан цагийн хуваарийн дагуу өөрт ойр байршлаас ажиллах боломжийг олгодог давуу талтай.

Нийт ажилтны тоо





График.5 Нийт ажилтны тооны өсөлт, жилээр

Премиум Нэксус ХК - Нийт ажилтан /Насны бүтэц, хүйсээр/



Сэнтрал фүүдс - Насны бүтэц, хүйсээр (%)




График 6. 2023 оны ажилтнуудын насны бүтэц

ХҮНИЙ НӨӨЦ, ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ

S1.1: Хүний нөөцийн тогтвортой байдал	Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)	66%
S1.2: Шинээр бий болгосон ажлын байр	Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо	890
S1.3: Сургалт	Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг	6.5
S3.1: Жендерийн бодлого, журам	Жендерийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Үгүй
S3.2: Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам	Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм
S3.3: Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм
S3.4: Ажилтнуудын хүйсийн харьцаа	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь	Эр-24% Эм-76%
S3.5: Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа	Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр-78% Эм-22%
S3.6: Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр-53% Эм-47%
S3.7: Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр-30% Эм-70%
S3.8: Жендерт суурилсан цалингийн зөрүү	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа	Эмэгтэй/ Эрэгтэй=1:1

График 6. 2023 оны ажилтнуудын насны бүтэц

АЖИЛТНЫ СЭТГЭЛ ХАНАМЖ

Компани жил бүр ажилтны оролцоо, сэтгэл ханамжийн судалгаа авдаг. 2023 онд авсан сэтгэл ханамжийн судалгааны дүнгээс харахад Премиум Нэксус ХК-ийн нийт ажилтны сэтгэл ханамж 72% байсан. Компанийн зүгээс ажилчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх, байгууллагын соёлыг бэхжүүлэх зорилгоор ажилчдад зориулсан төрөл бүрийн арга хэмжээ, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Сэтгэлд ойр гэр бүлийн хөтөлбөр
2. CU спорт арга хэмжээ
3. Happy Friday
4. CU 5 жилийн ойн арга хэмжээ
5. Wellness хөтөлбөр
6. Эрүүл мэндийн үзлэг
7. Хүүхдийн баяр
8. Хамт олны эерэг харилцаа өглөөний сургалт, уулзалт
9. Хувийн санхүүгийн менежмент өглөөний сургалт уулзалт

АЖИЛТНЫ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

Худалдаа үйлчилгээний салбарт ажилтны шилжилт хөдөлгөөн бусад салбартай харьцуулахад харьцангуй өндөр байдаг. Премиум Нэксус ХК-ийн хувьд 2020 оноос ажилчдын шилжилт хөдөлгөөнийг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Жишээлбэл, компанийн үнэт зүйлстэй нийцсэн ажилтныг сонгон шалгаруулах, гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулах, ажлын байр, ажлын цагийг уян хатнаар зохицуулах боломжийг бүрдүүлсэн.

Эдгээр ажлууд үр дүнгээ өгч буйн гол үзүүлэлт бол ажилтны эргэц буюу өмнөх жилийнхээс өөрчлөгдсөн үндсэн ажилтнуудын хувь тасралтгүй буурч 2020 онд 95% орчим байсан бол 2022 онд 71%, 2023 онд 66% болсон.





График 7. Эргэц

ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ

Премиум Нэксус ХК нь одоогоор жендерийн эрх тэгш байдлын талаар ямар нэгэн бие даасан бодлогын баримт бичиггүй боловч компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”, Хөдөлмөрийн гэрээнд ажил олгогч “ялгаварлан гадуурхалт, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас ангид ажлын байраар хангах үүрэгтэй”, ажилтан “бусад ажилчдад дарамт шахалт хүчирхийлэл, бэлгийн дарамт үзүүлэхгүй байх үүрэгтэй” гэж заасан.



CU компанийн хувьд үйл ажиллагааны үндсэн чиглэл нь худалдаа, үйлчилгээ, хүнсний үйлдвэрлэл бөгөөд салбарын нийтлэг жишгийн нэгэн адил эмэгтэй ажилтны тоо давамгайлдаг. 2023 оны тоон баримтаас харахад Премиум Нэксус ХК-ийн нийт ажилтны 70% нь эмэгтэй, 30% нь эрэгтэй байна. Удирдлагын түвшин дэх хүйсийн харьцааг авч үзвэл эмэгтэй ажилтны тоо анхан, дунд удирдах түвшинд 70%, гүйцэтгэх удирдлагын түвшинд эрэгтэй ажилтны тоо 47% байна. Төлөөлөн удирдах зөвлөлд 2023 онд 2 эмэгтэй гишүүн нэмэгдэн орж, нийт 9 гишүүдээс 7 нь эрэгтэй, 2 нь эмэгтэй гишүүн байна.

Эрэгтэй, эмэгтэй ажилчдын цалингийн харьцаа бүх түвшинд 1:1 байна.

2023 онд Nito байгууллагаас олгодог “Good Workplace Awards 2023”-т “Карьер хөгжлийг дэмжигч шилдэг ажил олгогч” номинацид шалгарсан.




График 9. Шилжилт хөдөлгөөн

Премиум Нэксус ХК-ийн хэмжээнд 2023 онд нийт 71 ажилтан менежер ба түүнээс дээш албан тушаалд дэвшсэн. Албан тушаалд дэвшсэн байдлыг хүйсээр ангилан харвал нийт албан тушаал дэвшсэн байдал эмэгтэйчүүд 64 хувийг эзэлж байна. Дэлгэрүүлбэл, менежерийн албан тушаалд дэвшсэн ажилтнуудын 66%, дунд түвшний захирлын албан тушаалд дэвшсэн ажилтнуудын 43%, гүйцэтгэх удирдлагын түвшинд дэвшсэн нийт ажилтнуудын 43% эмэгтэй ажилтан байсан. Харин сүүлийн 12 сард ажлаас чөлөөлөгдсөн байдлыг харвал нийт 4996 ажлаас чөлөөлөгдсөн ажилтан байснаас эмэгтэйчүүд 57 хувийг эзлэх бөгөөд сүүлийн 12 сард шинээр 6355 хүн ажилд авснаас үүний 60 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Тушаал дэвшсэн байдал	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эмэгтэй %
Сүүлийн 12 сарын хугацаанд Гүйцэтгэх удирдлагын түвшин рүү тушаал дэвшсэн нийт ажилтнуудын тоо	4	3	7	43%
Сүүлийн 12 сарын хугацаанд Дунд түвшний захирлын албан тушаалд дэвшсэн нийт ажилтнуудын тоо	4	3	7	43%
Сүүлийн 12 сарын хугацаанд Менежерийн албан тушаалд дэвшсэн нийт ажилтнуудын тоо	63	121	184	66%
Нийт менежер ба түүнээс дээш албан тушаалд дэвшсэн байдал	71	127	198	64%
Ажлаас чөлөөлөгдсөн байдал	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эмэгтэй %
Сүүлийн 12 сарын хугацаанд Гүйцэтгэх удирдлагын албан тушаалаас чөлөөлөгдсөн нийт ажилтнуудын тоо	1	3	4	75%
Сүүлийн 12 сарын хугацаанд Дунд түвшний захирлын албан тушаалаас чөлөөлөгдсөн нийт ажилтнуудын тоо	2	1	3	33%
Сүүлийн 12 сарын хугацаанд Менежерийн албан тушаалаас чөлөөлөгдсөн нийт ажилтнуудын тоо	103	168	271	62%
Сүүлийн 12 сарын хугацаанд Entry-level буюу хамгийн бага албан тушаалаас чөлөөлөгдсөн нийт ажилтнуудын тоо	2051	2667	4718	57%
Нийт ажлаас чөлөөлөгдсөн байдал	2157	2839	4996	57%
Ажилд авсан байдал	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эмэгтэй %
Сүүлийн 12 сарын хугацаанд Гүйцэтгэх удирдлагын түвшинд "гаднаас шинээр" ажилд авсан нийт ажилтнуудын тоо	1	2	3	67%
Сүүлийн 12 сарын хугацаанд Дунд түвшний захирлын албан тушаалд "гаднаас шинээр" ажилд авсан нийт ажилтнуудын тоо	4	5	9	56%
Сүүлийн 12 сарын хугацаанд Менежерийн албан тушаалд "гаднаас шинээр" ажилд авсан нийт ажилтнуудын тоо	95	263	358	73%
Сүүлийн 12 сарын хугацаанд Entry-level буюу хамгийн бага албан тушаалд "гаднаас шинээр" ажилд авсан нийт ажилтнуудын тоо	2448	3537	5985	59%
Нийт шинээр ажилд авсан байдал	2548	3807	6355	60%

Хүснэгт 8. Шилжилт хөдөлгөөн

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

2023 онд Премиум Нэксус ХК-д хөгжлийн бэрхшээлтэй ажилтан нийт ажилтны 4%-ийг эзэлж байсан. Энэ Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу ажил олгогчид тавьдаг үүрэгт бүрэн нийцэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу богиносгосон цагаар ажилладаг. Ажлын байрны зарыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй түгээх үүднээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоонуудтай хамтарч ажилладаг. Дэлгүүрүүдэд саажилттай, сонсголын бэрхшээлтэй зэрэг хүмүүс ажиллах нь элбэг. Зарим хүнсний үйлдвэрүүдэд тэргэнцэртэй хүмүүс ч ажиллах боломжтой, ажиллаж байсан түүх бий. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил олгосноор тэдэнд орлогоо нэмэгдүүлэхээс гадна нийгэмших, бие даах чадвар нь сайжрах зэрэг эерэг боломжуудыг бий болгож байна. Нөгөө талаас харахад бусад ажилтан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ойлгох, хүндлэх, тэдэнтэй зөв зохистой харьцах, халамжлах мэдлэг олж авч байна. Ингэснээрээ нийгмийн олон талт, ялгаатай байдлын оролцоо, тэгш боломжийг хангах боломж бүрдүүлж буй нь маш том эерэг нөлөөлөл юм.

СУРГАЛТ

Дээрх хүйсээр ангилсан дүн шинжилгээнээс харахад Компани нь эмэгтэй ажилтнуудыг удирдах, манлайлах чиглэлд сурч хөгжих боломжоор хангадаг бөгөөд нийт манлайллын сургалтын үр ашиг хүртэгчдийн 74.36 хувь нь эмэгтэй ажилтнууд байна.

Харин жендерийн сургалт, мэдээлэл авсан зөвхөн 1 менежерийн түвшний ажилтан байгаа бөгөөд ханган нийлүүлэгчдийн бүртгэлийг хүйсээр ангилдаг практик одоогоор байхгүй байна. Компани нь сүүлийн 12 сарын хугацаанд 2 удаагийн жендерийн эрх тэгш байдал, хүртээмжтэй, олон талт байдалтай холбоотой мэдээллийг олон нийтэд түгээжээ.

S 4.1: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан олон нийтэд нээлттэй бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм
S 4.2: Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь	4 %
S 4.3: Оффисын хүртээмж	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн оффис, байгууламжтай юу	Үгүй
S 4.4: Торгууль	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөөгүйн улмаас төлсөн торгуулийн хэмжээ	0 Төгрөг

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО

“Премиум Нэксус” ХК нь “Ажилтан бүр өглөө ажилдаа эрүүл саруул ирээд, буцаад харихдаа эрүүл саруул гэртээ харих, хэрэглэгч аюулгүй орчноор үйлчлүүлэх” гэсэн зорилго тавьж ажилладаг. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд ХАБЭА менежментийн тогтолцоог нэвтрүүлэн, хэрэгжүүлж ажилладаг. Компанийн ХАБЭА менежментийн тогтолцоо нь PDCA (Төлөвлөх- Хэрэгжүүлэх-Хянах-Сайжруулах) загварыг дагаж мөрддөг.

“Премиум Нэксус” ХК нь 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн Гүйцэтгэх захирлын А/20-ны 29 тушаалаар анх ХАБЭА-н бодлогыг баталсан. ХАБЭА нийт 12 журамтай.

- | | |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------|
| 1. ХАБЭА-н ерөнхий журам | 7. ХАБЭА-н сургалт, зааварчилгаа өгөх журам |
| 2. Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл ашиглах журам | 8. ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн журам |
| 3. Аюулыг илрүүлэх, мэдээлэх, залруулах журам | 9. Гэрээт болон туслан гүйцэтгэгч нарт тавигдах ХАБЭАБО-ны шаардлага |
| 4. ХАБЭА, БО үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, аюултай тохиолдол, осолд дөхсөн тохиолдлыг судлан бүртгэх журам | 10. Онцгой байдлын үеийн бэлэн байдал, харилцаа холбоо, авах арга хэмжээний журам |
| 5. Галын аюулгүй байдлын журам | 11. Ажиллагсдын эрүүл мэндийн хяналтын журам |
| 6. ХАБЭА-н дотоод хяналтын журам | 12. Лабораторид мөрдөх ХАБЭА журам |

Премиум Нэксус ХК-ийн ХАБЭА алба ХАБЭА менежментийн тогтолцооны хэрэгжилт, сайжруулалтыг хариуцаж, компанийн удирдлага ажилчдад мэргэжлийн дэмжлэг үзүүлж ажилдаг. ХАБЭА алба нь Гүйцэтгэх захирлын удирдлагад шууд харьяалагддаг бөгөөд 2 менежер, 3 мэргэжилтэн, 1 эмч гэсэн бүрэлдэхүүнтэй.

Зөвхөн байгууллага дотроо төдийгүй гэрээт болон туслан гүйцэтгэгч нарт ХАБЭАБО соёлыг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого мэргэжлээс шалтгаалах өвчнөөс сэргийлэх зорилгоор “Гэрээт болон туслан гүйцэтгэгч нарт тавигдах ХАБЭАБО-ны шаардлага журам”-ыг хэрэгжүүлдэг.

АЖИЛТНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Компанийн зүгээс ажилтны аюулгүй байдлыг хангахад чиглэсэн олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Бүх дэлгүүрийг камераар тоногловсон;
- Харуул хамгаалалтын компанитай гэрээ байгуулсан. Дэлгүүрт аюултай нөхцөл үүсэхэд хамгаалалт дуудах тусгай товч байдаг бөгөөд товч дарснаас хойш 5-10 минутын дотор хамгаалалтын баг ирдэг;
- Ажилтанд ХАБЭА сургалтын үеэр аюултай нөхцөл үүсэх үед авах арга хэмжээний талаар заавар, зөвлөмж өгдөг;
- Эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтныг гэнэтийн ослын даатгалд хамруулсан. Ингэснээрээ ажлын байрандаа, эсвэл гэртээ харих, ажилдаа ирэх замдаа ямар нэг осолд орох, гэмт халдлагад өртсөн тохиолдолд нөхөн олговор авах боломжийг бүрдүүлсэн;
- Ажилтан гэрээсээ ажилд ирэх, буцах маршрутыг тогтоосон.

Гэнэтийн ослын даатгалаас гадна гуравдагч этгээд болон хамааралтай этгээдүүдийн бие эрхтний гэмтэл бэртэл, эрүүл мэнд, амь насанд учруулах хохирол, түүнчлэн эд хөрөнгийн эвдрэл, хохирлыг хамаарсан ерөнхий хариуцлагын даатгалтай. "Гэрээт болон туслан гүйцэтгэгч нарт тавих ХАБЭА шаардлага" журамд гэрээт компани өөрийн ажилтнуудыг гэнэтийн ослын даатгал, жолоочийн хариуцлагын даатгал, мэргэшсэн жолоочийн даатгал, машин, тоног төхөөрөмжийн даатгалд хамрагдахыг шаарддаг.

ОСЛЫН МЭДЭЭЛЭЛ

2023 онд нийт 13 ослын тохиолдол бүртгэгдсэн бөгөөд үүнээс эмнэлгийн тусламж-7, анхны тусламж-5, ажлын байрнаас гарч яваад зам тээврийн осолд өртсөн-1 тохиолдол гарсан. 2023 онд бүртгэгдсэн гэрээт болон туслан гүйцэтгэгч нарт гарсан осол байхгүй.

Даатгалын төрөл	Даатгалд хамрагдагсад
Гэнэтийн ослын даатгал	Байнгын гадуур ажилладаг оффисын ажилчид, түгээлтийн төв, үйлдвэрийн ажилчид
Олон улсын эрүүл мэндийн даатгал	Томилолтоор ажиллах удирдлагын түвшний ажилтан
Томилолтын гэнэтийн ослын даатгал	Томилолтоор ажиллах ажилчид
Байгууллагын ерөнхий хариуцлагын даатгал	Бүх үйл ажиллагаа
Эд хөрөнгийн даатгал	Салбар дэлгүүр, хуурай түгээлтийн төв, хүйтэн хэлхээт түгээлтийн төв, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн гал тогоо
Бараа материалын үлдэгдлийн даатгал	Дэлгүүр, хуурай түгээлтийн төв
Тээврийн хэрэгслийн даатгал	Барилга ашиглалтын албаны машин

Ангилал	Зөрчлийн тоо	Эзлэх хувь
Эмнэлгийн тусламж	7	53.8%
Анхны тусламж	5	38.5%
ХЧТА	0	0.0%
ХЧБА	0	0.0%
Нас баралт	1	7.7%
Нийт ОДТ	13	100.0%

ХАБЭА СУРГАЛТ

“Премиум Нэксус” ХК нь ХАБЭА сургалтыг ажлын байрны онцлогт тааруулан өөр өөр сэдвээр зохион байгуулсан.

Ажилтнуудад зориулсан сургалт

- Нийт ажилтны ХАБЭА сургалт
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөл, хурц хордлогоос урьдчилсан сэргийлэх нь
- Ажлын байранд анхан шатны тусламж үзүүлэх сургалт
- Аюулгүй ажиллагааны соёл
- Эрсдэлийн үнэлгээ
- Аюулгүй ажиллагаа
- Гамшгийн тухай ерөнхий ойлголт, гал түймрээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах
- Галын аюулгүй байдал хангах, урьдчилан сэргийлэх сургалт
- ХАБЭА-н тухай чиглэл олгох сургалт
- Салбар дэлгүүрт үүсэж болох ХАБЭА эрсдэл хэрхэн шийдвэрлэх тухай сургалт
- Анхны тусламж үзүүлэх
- Өндрийн сургалт
- Сэрээт өргүүрийн операторын сургалт

Салбарын менежерт зориулсан сургалт

- ХАБЭА-н аюулгүй ажиллагаа сургалт
- Ажил олгогч, удирдах ажилтны ХАБЭА сургалт
- Салбар дэлгүүрт үүсэж болох ХАБЭА эрсдэл хэрхэн шийдвэрлэх тухай сургалт
- Анхны тусламж үзүүлэх
- Бүсийн менежер, дэлгүүрийн зөвлөх, ахлах ажилтнуудад зориулсан сургалт
- ХАБЭА-н сургалт

Нэг ажилтны хамрагдах ХАБЭА сургалтын нийт үргэлжлэх хугацаа 2-3 цаг. ахлах ажилтан, менежерүүдийн хувьд 10-12 цаг үргэлжилдэг. Нэг ажилтанд ногдох ХАБЭА-н сургалтын жилийн дундаж хугацаа 2 цаг 08 минут байна. Энэ үзүүлэлт харьцангуй бага байгаа нь ажилчдын эргэцтэй холбоотой юм.

CU нь зөвхөн өөрийн ажилтанд төдийгүй фрайнчайз эрх эзэмшдэг хувь хүмүүст зориулж тэдний ХАБЭА соёлыг дээшлүүлэх зорилгоор “ХАБЭА аюулгүй орчныг бий болгох нь” сургалтыг зохион байгуулдаг.

АЖИЛТНЫ ЭРҮҮЛ МЭНД

“Хөдөлмөрийн дотоод журам”-ын 47-р заалтад “Ажилтны эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг компанийн жилийн бизнес төлөвлөгөөнд тусгасан төсөв, ХАБЭА-н тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу зохион байгуулна”, 60-р заалт “ Ажилтныг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулж, ажлын нөхцөлөөс хамаарч ноцтой өвчлөлт гарсан бол яаралтай арга хэмжээ авна”, 61-р заалт “Ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийг шаардлагын төвшинд хангаж, цэвэрлэгээ, ариутгал, устгалын ажлыг тогтмол хийнэ” гэж тус тус заасан.

CU жил бүр ажилтнуудын дунд хөл бөмбөг, сагсан бөмбөг, волейбол, дартс, esports-ийн тэмцээнүүд зохион байгуулдаг. Мөн “Wellness” хөтөлбөр хэрэгжүүлж ажиллагсдад Энканто спорт клубт фитнес болон скуаш хичээлд хамрагдаж, биеийн тамираар хичээллэж, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхийг дэмждэг.

Шинээр ажилд орж байгаа төв оффисын ажиллагсдаас бусад бүх ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулдаг. Үзлэгийн зардлыг компаниас хариуцан гаргадаг.

Ажилтны эрүүл мэндийг тандах, ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчнийг эрт үед илрүүлэх зорилгоор жил бүр ажилтнуудыг (дэлгүүрийн үндсэн менежер, оффисын ажилтнууд, Түгээлтийн төв, Хоолны үйлдвэрийн ажилтнууд хамрагдсан) эрүүл мэндийн хугацаат үзлэгт компанийн зардлаар хамруулдаг.



Барилга байгууламжийн хүртээмжтэй байдал

Тэргэнцэрт зориулсан налуу зам: CU дэлгүүрүүдийн хувьд объектуудаа түрээсэлдэг учир тэргэнцэртэй иргэн орох боломжийг хангасан налуу замгүй объектууд байх тохиолдлууд байна. Налуу замтай ч бариул хэт хол байрласан, хэт эгц өндөр гэхчлэн стандартын дагуу баригдаагүй байх нь элбэг.

Үйлдвэрийн объектуудын хувьд мөн адил, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн нь хомс тул зарим үйлдвэрлэгчдийн хувьд үйлдвэрийн байраа солиход хөгжлийн бэрхшээлтэй ажилчин нь ажиллах боломжгүй болсон зэрэг тохиолдол гардаг.

Галын аюулгүй байдал

Нийт 17 салбарын гал унтраах шуурхай төлөвлөгөө боловсруулж батлуулсан. Нийт 133 салбарын галын тохижилтын тайлан бэлтгэсэн. Салбар бүр галын аюулгүй байдлыг хангах зорилгоор 25мкв тутамд 1 гал унтраагуур, галын хөнжил, угаарын хий мэдрэгч сенсороор тоноглогдсон байх ба тэдгээрийн хугацааг тогтмол хяналтын хуудсаар шалгадаг байна.

Хүнсний үйлдвэр нь 100% автомат гал хамгааллын системтэй. Мөн газын байгууламж мэдрэгч сенсортой учир газ алдагдах тохиолдолд автоматаар хэрэглээг зогсоох, унтрах тохиргоотой.

Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл

Үйлдвэрлэлийн хортой аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, өвөл зуны ажлын хувцас, гутал олгодог. Хамгаалалтын малгай, нүдний шил, нүүрний хамгаалалт, бээлий, амны хаалт, чихэвч, чихний бөглөө, өндрийн бүс, нурууны бүс зэрэг нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцас, гутлыг компаниас үнэ төлбөргүйгээр ажилтнуудад олгодог.

Зочид, ажил шалгах, танилцах зорилгоор талбай, үйлдвэр, түгээлтийн төвд ажиллах хүмүүст гэрэл ойлгогч бүхий хантааз, хамгаалалтын малгай, хамгаалалтын нүдний шил, амны хаалт, нөмрөг, хормогч олгодог.

ХОТ СУУРИН ГАЗРЫГ САЙЖРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

CU дэлгүүрээр үйлчлүүлж буй сая хүн дараах үйлчилгээг ямар нэг худалдан авалт хийх нөхцөлгүйгээр санал болгож, нийслэл болон салбар дэлгүүр байршиж буй орон нутгийн хоол үйлчилгээний соёл, стандартыг өөр түвшинд авчраад 4 жил болжээ.



Ариун цэврийн газар:

Нийслэлд олон нийтийн ариун цэврийн байгууламжийг дангаар шийдэж өгсөн нь нийслэлийн иргэдийг ая тохитой амьдрах, олон жилийн турш гаргалгаа олдоогүй асуудлын шийдлийг бий болгосон хэрэг юм.



Гадна талбайн цэвэрлэгээ:

CU дэлгүүрүүд гадаад орчны 50м талбайгаа тохижуулсан гэрэлтүүлэгтэй, халтиргаа гулгаанаас хамгаалж цэвэрлэсэн байх шаардлага тавьдаг.



24 цагийн камержуулалт:

1 сарын хугацаатай хадгалагддаг камерын бичлэг хийгддэг бөгөөд хүмүүс юмаа мартаж орхих, хулгай, гэмт хэрэгт өртөх гэх мэт тохиолдлуудад холбогдох байгууллагын зөвшөөрлөөр бичлэг шүүж нотолгоо болсон тохиолдлууд бий.



Үнэгүй Wi-Fi цэг:

Хотын төв гэлтгүй захын бүсүүдэд кофе шоптой адил үйлчилгээ үзүүлэх ач холбогдолтой юм.



Шуудангийн үйлчилгээ:

Stora хүргэлтийн цэгүүд тодорхой цэгүүдэд байрласан. Мөн төрийн үйлчилгээний киоск цэгүүдийг байрлуулахаар төрийн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.



Хүргэлтийн үйлчилгээ:

Ковид-19 цар тахлын үед хүргэлтийн үйлчилгээг хэрэгжүүлж байсан нь өндөрлөсөн бөгөөд цар тахлын үед ч мөн зогсолтгүй хэрэглэгчдэдээ ойр байх зарчмыг баримтлан хэрэглэгчид хамгийн ойрын салбараасаа хамгийн хурднаар хүргэлтийг авах боломжтой байснаараа онцлог.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА, ИЛ ТОД БАЙДАЛ

Премиум Нэксус ХК нь Премиум Корпорэйшн ХХК-н Гүйцэтгэх захирлын 2020 оны 01 сарын 16 өдрийн А-03 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн хариуцлага, олон нийтийн харилцааны талаар баримтлах бодлого”-г үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлогын барим бичиг боловсруулж, хэрэгжүүлээгүй боловч олон талт хамтын ажиллагааны хамтын чармайлтаар олон нийтийн сайн сайхан байдалд зориулсан төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж байна.

Нийслэлийн засаг даргын тамгын газар болон “Премиум Корпорэйшн” ХХК нарын хооронд 2022 оны 10 дугаар сарын 13-ний өдөр байгуулсан Хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд байгаль орчны чиглэлээр болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр арга хэмжээ авч аж

Дархан-уул аймаг, дархан сумын засаг даргын тамгын газар болон Премиум Нэксус ХК хооронд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд Дархан сумын хүн амыг эрүүл хүнсээр хангаж мөн ажлын байрыг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж байна.

S5.1: Оролцогч талууд, олон нийтийн оролцоо	Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу?	Тийм
---------------------------------------------	-------------------------------------------------------------------------	------

БАЙГАЛЬ ОРЧИН

Хүнсний аюулгүй байдал ба бэлтгэн нийлүүлэгчдийн чадавхжуулах

CU Сүлжээ дэлгүүрийн хувьд хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллах нь нийт үйлчлүүлэгчдийн эрүүл, аюулгүй хүнс авч хэрэглэхэд хамгийн чухал асуудал юм. Манай компани хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллах хүрээнд хамтран ажилладаг хоолны бүтээгдэхүүн нийлүүлдэг нийлүүлэгч нарыг хөгжүүлэх зорилгоор ажлын байрны угтвар нөхцөлийг сайжруулах, эрүүл ахуйн дадлыг байнга мөрдүүлэн ажиллуулахын тулд “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийг санаачлан эхлүүлсэн. Энэхүү хөтөлбөр эхлээд 2023 ондоо нийт 6 нийлүүлэгч НАССР стандартыг хэрэгжүүлэн, эрх бүхий байгууллагын баталгаажилтад орж сертификат гардан авсан. Хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлэн 2024 ондоо дахин 5 нийлүүлэгчийг НАССР стандарт хэрэгжүүлэн баталгаажилт авахаар бэлтгэл ажилдаа ороод байна.

ФРЕШ БОКС ХХК

ГОО ЛАЙФ ЛОРИС ХХК

АЛТАЙДЭЛГЭР ХХК

БЛЮЖЭЙ КАТЕРИНГ ХХК

ӨСИС ТЖМ ХХК

ФРИЙ ФҮҮД ХХК

Өнөөдөр тус сүлжээний 374 салбараар өдөр бүр 150,000 орчим үйлчлүүлэгч үйлчлүүлж, дундажаар 73,000 ширхэг бэлтгэсэн хоолыг худалдан авч байна. Улмаар сүлжээний хэмжээнд борлуулагдаж буй нийт хоолны 38 хувийг CU хоолны үйлдвэрт үйлдвэрлэдэг бол, 62 хувийг бусад дотоодын хоол үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд нийлүүлдэг.

Эдгээр аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаандаа НАССР-ийн стандарт нэвтрүүлснээр түүхий эд бэлтгэн нийлүүлэлтээс эхлэн үйлдвэрлэх, түгээх, хадгалах, хэрэглэгчид хүргэх бүхий л үе шатанд бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг ханган нарийн хяналт шалгалтын дор эрүүл, баталгаатай хоол хүнс үйлдвэрлэж, хэрэглэгчдэд найдвартай аюулгүй бүтээгдэхүүнээр үйлчлэх боломжтой болж байна.

Компани “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийг цаашид хэрэгжүүлж үндэсний үйлдвэрлэгч нарыг хөгжүүлэх, тэдний чадавхыг сайжруулах чиглэлд үргэлжлүүлэн хамтран ажиллана.

Хог хаягдал

Үйл ажиллагаанаас гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, эх үүсвэр дээр нь ангилан ялгах, дахин боловсруулах цогц тогтолцоог нэвтрүүлсэн. Бүх дэлгүүрүүдэд хогийг төрөлжүүлэн ангилах стандартын шаардлага хангасан сав байрлуулж, үйлдвэрийн хоолны хаягдлыг гахайны фермд, ашигласан тосыг савангийн үйлдвэрт, цаасан хайрцаг рулоныг дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлж, ландфилд зайлуулагдах хогийг тухайн дүүргүүдийн Тохжилт үйлчилгээний төвүүдтэй байгуулсан гэрээний дагуу 7 хоног тутам ачуулж, орчны ариутгал халдваргүйжил хийж хэвшсэн.

Хүлэмжийн хийн ялгарлыг дүйцэн хамгаалах

Нийслэлийн Захирагчийн Ажлын Албанаас зохион байгуулж буй “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцэгжүүлэх” ажлыг Премиум Нэксус ХК нь дэмжин ажиллаж ногоон байгууламжгүй сүлжээ дэлгүүрийн 43 салбарыг хамруулж 75 ширхэг бортоготой цэцэглэдэг мод болон гоёлын цэцгийг тарьж ажилласан.

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ



“CU ЧАМД ТУСАЛЪЯ” хөтөлбөр

2021 оноос Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын Гэр бүл хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх газартай хамтран бага насны хүүхдийг төөрхөөс сэргийлэх, төөрсөн хүүхдийг аюулгүй байлгах, гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилготой хэрэгжүүлж эхэлсэн “CU ЧАМД ТУСАЛЪЯ” хөтөлбөр үргэлжилж байна. CU сүлжээ дэлгүүр нь хурдацтай, далайцтай тэлж Улаанбаатар хотын гудамж талбайд аюулгүй, гэрэлтэй, харуул хамгаалалттай, гадна, доторхоо бүрэн камержуулсан орчныг бүрдүүлж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлд бодитой хувь нэмэр оруулж байна.



ICU хөтөлбөр

Премиум Нэксус ХК нь хүүхэд багачуудыг аюул ослоос хамгаалах, төөрсөн хүүхдүүдийг эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгөх зорилготой ICU хөтөлбөрийг Нийслэлийн Цагдаагийн Удирдах Газартай хамтран 2023 оноос хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөр нь зөвхөн төөрсөн хүүхдүүдийг хамгаалаад зогсохгүй, гэр бүлийн хүчирхийллээс үүдсэн аюултай нөхцөл байдлын үед хүүхдүүдэд түр орогнох байр болж, аюул өнгөртөл хамгаалах орчныг бүрдүүлж өгдөг. Хөтөлбөр эхэлснээс хойш хугацаанд гэрээсээ төөрсөн 8 хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагчид нь аюулгүй хүлээлгэн өгсөн.



Гамшгийг даван туулах арга хэмжээ

Үерийн голомтод ажилласан албан хаагчдад үйлдвэрийн хоол бэлтгэж хүргүүлсэн.

Замын хөдөлгөөн, ачааллыг бууруулах зорилгоор Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газраас гаргасан шийдвэртэй холбоотой идэр есийн хүйтэнд автомашины зохицуулалтыг хийн өдөр шөнийг үл харгалзан ажиллаж байсан замын цагдаагийн албан хаагчдад үнэгүй цай, кофегоор 3 хоногийн турш CU бүх салбараар үйлчилгээ үзүүлсэн. (Нийт 3,618,575.00 төгрөг)

Хамтын ажиллагааны өргөжилт

2023 оны 10 дугаар сарын 5-нд CU брэнд нь илүү бүтээлч, үр дүнтэй, хог хаягдлын менежментийг бий болгон, үлгэр жишээч байгууллага болох зорилтын хүрээнд HSPIM-Эрүүл мэндийн нийгмийн бодлогын хүрээлэнтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа. Энэхүү санамж бичиг нь HACCP стандартаар баталгаажсан хоолны үйлдвэр, түгээлтийн төвийн хуурай агуулах, хүйтэн агуулах, болон салбар дэлгүүрүүдэд байгальд ээлтэй, олон улсын стандартад нийцсэн зохистой хог хаягдлын менежментийг нэвтрүүлэн хэвшүүлэхэд чиглэж байна.

CU брэнд нь 2023 онд улсын хэмжээнд яаралтай мэс ажилбар хийлгэх шаардлагатай мэдрэл болон зүрх судасны хүнд, хөнгөн хэлбэрийн оноштой 1000 гаруй хүмүүс тогтмол үйлчлүүлдэг Шастины нэрэмжит Улсын 3-р эмнэлгийн Мэдрэл болон Зүрхний мэс заслын хүлээлгийн танхимыг засварлан тохижуулж эмнэлгийн хамт олонд хүлээлгэн өгсөн юм.



Дархан сумын хүн амыг эрүүл хүнсээр хангах

CU хоолны үйлдвэр нь 2023 оны 3 дугаар сард НАССР стандартын баталгаажуулалт хийгдэж, гэрчилгээ авсан бөгөөд хамтран ажилладаг хоолны нийлүүлэгч нарт манлайлан үзүүлэн ажиллаж байна.

2023 оны 3 сард Дархан сумын гарааны бизнес эрхлэгч нартай уулзаж Дархан сумын ЖДҮ хамтран зохион байгуулж 25 ААН хамрагдан оролцож хэрхэн CU-д бүтээгдэхүүн нийлүүлэх, эрүүл ахуй чанар стандартын хүнс хэрхэн үйлдвэрлэх талаар сургалт болон уулзалт хийсэн.



Ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

Нийт 4 салбарт 42 ажлын байр бий болж, 8 ажилтан манлайллын сургалтад хамрагдаж менежерээр ажиллаж байна. 34 ажилтанд ажлын цагаар уян хатан зохицуулалтыг ажил эрхлэх боломж олгосон.

Премиум Нэксус ХК-д одоогоор нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журам байхгүй байна.

Премиум Нэксус ХК-ийн “Үйлчлүүлэгчийн санал, гомдлыг шийдвэрлэх журам” нь 2022 оны 6 сарын 20-ны өдрийн Гүйцэтгэх захирлын тушаалаар, Сэнтрал Фүүдс ХХК-н “Хэрэглэгчийн санал, гомдлыг шийдвэрлэх журам” нь Гүйцэтгэх захирлын 2022 оны 11 сарын 15-ны өдрийн тушаалаар тус тус батлагдсан.

Журмын хүрээнд үйлчлүүлэгчээс ирж буй гомдлыг ноцтой, ноцтой биш гэсэн 2 төрөлд ангилах бөгөөд дараах сувгуудаар хүлээн авдаг. Дуудлага хяналтын төв бүх сувгаар ирсэн гомдол, саналыг хүлээн авч нэгдсэн бүртгэл үүсгэх бөгөөд үйлчлүүлэгчийн санал, гомдлын мөрөөр анхан шатны мөшгөлт хийж, гомдол гаргагчтай холбогдож, гомдлын дүгнэлт гаргаснаар гомдлыг хаадаг.

S5.2: Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого журам	Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журамтай юу? (Үүнд газар чөлөөлөлт багтана)	Үгүй
S5.3: Санал гомдлыг шийдвэрлэх бодлого/журам	Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу?	Тийм
S5.4: Олон нийтэд ил тод мэдээлэх	Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу?	Тийм
S5.5: Ажилчид/олон нийтийн санал гомдол	Ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг шийдвэрлэсэн хувь	100%

Ангилал	Гомдлын тоо	Санал хүсэлтийн тоо	Гомдол эзлэх хувь	Санал хүсэлт эзлэх хувь
CU аппликэйшн-тэй холбоотой	12		1.0%	0.0%
Ажилтан, үйлчлүүлэгчийн эрүүл мэнд хохирсон	9		0.7%	0.0%
Ажилтны харилцаа	114	14	9.4%	23.3%
Амт үзэмж муу	242	18	19.9%	30.0%
Ар гэрийн гомдол	12		1.0%	0.0%
Бусад	37	3	3.0%	5.0%
Бүтээгдэхүүн муудсан, чанар алдагдсан	241	1	19.8%	1.7%
Бүтээгдэхүүн тасалдал	1	1	0.1%	1.7%
Бүтээгдэхүүний хадгалах хугацаа дууссан	16		1.3%	0.0%
Гаднын биет илэрсэн	303	1	24.9%	1.7%
Сав баглаа боодол гэмтэлтэй	2		0.2%	0.0%
Түгээлтийн жолоочийн харилцаа	5		0.4%	0.0%
Үйлчилгээнд бэлэн бус	58	18	4.8%	30.0%
Хадгалалтын горим алдагдсан	2		0.2%	0.0%
Харшил	1		0.1%	0.0%
Хаяг шошго, сав баглаа боодол гэмтэлтэй	9	1	0.7%	1.7%
Хордлого	105		8.6%	0.0%
Хүргэлтийн үйлчилгээ	36	1	3.0%	1.7%
Цэвэрлэгээ /үйлчилгээний тав тух/	12	2	1.0%	3.3%
Нийт	1217	60	100%	100%

Хүснэгт 11. Санал, гомдол, хүсэлт

Ноцтой гомдол	Ноцтой биш гомдол	Гомдол хүлээн авах суваг
<ul style="list-style-type: none"> • Хоолны хордлого • Бүтээгдэхүүнээс гаднын биет илэрсэн • Хугацаа дууссан бүтээгдэхүүн худалдсан, бүтээгдэхүүн муудсан • Ажилтны бүдүүлэг харилцаа • Ажилтан, үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан 	<ul style="list-style-type: none"> • Амт үзэмж муу • Үйлчилгээнд бэлэн бус • Хүргэлтийн үйлчилгээ • Цэвэрлэгээ /үйлчилгээний тав тух/ • CU аппликэйшн-тэй холбоотой • Бусад 	<ul style="list-style-type: none"> • Дуудлага хяналтын төв 7733010 • Имэйл: callcenter@cumongol.mn • CU аппликэйшн • Сошиал хуудас: Facebook, Instagram хуудаснууд дахь чатбот • Үйлчлүүлэгч салбар дэлгүүрт биечлэн гаргах

Хүснэгт 12. Гомдлын төрөл

ТОГТВОРТОЙ ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ МЕНЕЖМЕНТ

2023 онд Премиум Нэксус ХК нийт 318,5 тэрбум төгрөгийн худалдан авалт хийснээс 97 хувийг дотоодын бэлтгэн нийлүүлэгч, ААН, байгууллагаас авсан худалдан авалт эзэлж байна. Хүснэгт 13 дээрээс харна уу.

“Премиум Нэксус” ХК-ийн “Худалдан авалтын үйл ажиллагааны журам”-д байгаль орчинд ээлтэй, сөрөг нөлөөгүй, эрчим хүчний хэмнэлттэй, дахин боловсруулан ашиглах боломжтой бараа, үйлчилгээг сонгон компанийн байгаль, нийгэмд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зарчмын баримтлахаар заасан.

2023 онд CU-д 4882 нэртөрлийн бүтээгдэхүүнийг 473 нийлүүлэгч нийлүүлснээс 41% нь буюу 193 нь үндэсний үйлдвэрлэгч байна.

Премиум Нэксус ХК-ийн хувьд хүнсний аюулгүй байдлыг хангасан бүтээгдэхүүн нийлүүлэгчтэй хамтарч ажиллах нь хамгийн чухал асуудал юм. Нийт 374 гаруй салбар дэлгүүрээр өдөрт 82,000 гаруй ширхэг бэлтгэсэн хоол худалдсан. Сүлжээ дэлгүүрийн хэмжээнд борлуулагдаж буй нийт хоолны 24 хувийг CU хоолны үйлдвэрт үйлдвэрлэдэг бол, 76 хувийг дотоодын хоол үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд нийлүүлдэг.

2023 онд 21 дотоодын хоол үйлдвэрлэгчийн 100 орчим нэр төрлийн хоолыг сүлжээ дэлгүүрээр дамжуулан хэрэглэгчдэд хүргэсэн. CU компани 2022 оноос бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдлыг хангахын тулд хоолны бүтээгдэхүүн нийлүүлэгч нарыг хөгжүүлэх, бүтээгдэхүүний чанар, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийг санаачлан эхлүүлсэн. Хөтөлбөрт нийт 12 хоолны үйлдвэр хамрагдаж, чанар, хүнсний аюулгүй байдлын талаар сургалт, зөвлөгөө авч, Эгзэгтэй цэгийн аюултай байдлыг хянах тогтолцоог (НАССР) нэвтрүүлсэн. НАССР-ийн стандарт нэвтрүүлснээр түүхий эд бэлтгэн нийлүүлэлтээс эхлэн үйлдвэрлэх, түгээх, хадгалах, хэрэглэгчид хүргэх бүхий л үе шатанд бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг ханган ажиллаж, эрүүл ахуйн шаардлага хангасан хоол хүнс үйлдвэрлэх нөхцөлийг бүрдүүлдэг. 2023 онд Фреш Бокс ХХК, Алтайдэлгэр ХХК, Өсис Тжм ХХК, Гоо Лайф Лорис ХХК, Блюжэй Катеринг ХХК, Фрий Фүүд ХХК зэрэг 6 компани НАССР стандартыг амжилттай хэрэгжүүлж, баталгаажуулалт хийлгэсэн. 2024 онд дахин 5 хоол үйлдвэрлэгч НАССР стандартын баталгаажуулалтын аудитад орохоор бэлдэж байна.

S 6.1: Худалдан авалтын бодлого, журам	Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжийг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?
S 6.2: Дотоодын худалдан авалт	Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь
S 6.3: Тогтвортой, ногоон худалдан авалт	Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь

Нийт худалдан авалт		Хувиар
Гадаад худалдан авалт	9,627,958,893	3 %
Дотоод худалдан авалт	308,893,372,123	97 %
Нийт	318,521,331,015	100.00 %


Хүснэгт 13. 2023 оны худалдан авалтын дүн

Бэлтгэн нийлүүлэгч	Бэлтгэн нийлүүлэгчийн тоо	Бүтээгдэхүүний төрөл
Гадаад	280	3602
Дотоод	193	1280
Нийт	473	4882

Хүснэгт 14. Бэлтгэн нийлүүлэгчдийн тоо

ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ

1. Компанийн засаглал
2. Авлига ба ёс зүй



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Премиум Нэксус ХК (“Компани”)–ийн засаглалын бүтэц нь Монгол Улсын холбогдох хууль, дүрэм журамд нийцсэн, үндсэн үйл ажиллагааны чиглэл, бодлого, стратегийг тодорхойлох, нөөц, дотоод хяналт, эрсдэлийг зөв зохистой удирдах, гүйцэтгэх удирдлагыг удирдан чиглүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байдаг.

Компани нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс болон олон улсад танигдсан шилдэг туршлага, зарчмуудыг баримталж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд сайн засаглал нь бизнесийн стратегийг хэрэгжүүлэх, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, тэдгээрийн ашиг сонирхлыг хамгаалах, бизнесийн ёс зүй, ил тод, шударга байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг хэмээн үздэг.

G1.1: Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?	Тийм
---------------------------------------------	-------------------------------------------------------------------------	------

КОМПАНИЙН БҮТЭЦ

Премиум Корпорэйшн 2015 онд өөрийн 100 хувийн хөрөнгө оруулалтаар Сэнтрал Экспресс нэртэй Монголын анхны конвинеенс дэлгүүрийг нээж байв. 2017 онд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-г байгуулж, 2018 оны 8-р сард дэлхийн конвинеенс дэлгүүрийн жишиг стандартын төлөөлөл, БНСУ-ын

Би Жи Эф Ритэйл ХК-тай хамтран ажиллаж CU брэндийн франчайз эрхийг хүлээн авч, компанийн нийт хувьцааны 10 хувийг эзэмшүүлэх хөрөнгө оруулалт татаж Монголын зах зээлд нэвтрүүлсэн. БиЖиЭф Ритэйл компани нь БНСУ-д 18,000 гаруй CU салбар дэлгүүртэй,

жижиглэн худалдааны зах зээлийн тэргүүлэгч компани юм. 2021 онд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь Монголын Хөрөнгийн Бирж дээр IPO амжилттай хийж хувьцаат компани болсон ба улмаар 2023 оны эцэст хувьцаа эзэмшигчдийн хурлаар хөгжлийн дараагийн шатандаа гарах шийдвэрээ баталж компанийн нэрээ Премиум Нэксус ХК болгон өөрчилсөн. Уг өөрчлөлтийн эхлэл нь шинээр хувьцаа гаргах замаар босоо интеграцийн хөрөнгө оруулалт болох Чингис Шар Айраг ХХК, Чингис Шар Айраг Клуб ХХК, Сэнтрал Коммерс ХХК, Сэнтрал Кофе Рөүстинг ХХК болон Стора Централ ХХК нарыг нэгтгэсэн.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Компани нь олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох албан ёсны зөвшөөрлөө 2021 оны 10-р сарын 13-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо ("СЗХ")-ноос авч 2021 оны 11-р сарын 03-ны өдөр Монголын хөрөнгийн бирж ХК ("МХБ")-ийн III дугаар ангиллаар нийтэд санал болгон үнэт цаасны анхдагч арилжаагаа амжилттай дуусгаж, 2021 оны 11-р сарын 12-ны өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаагаа нээснээр нээлттэй хувьцаат компани болсон бөгөөд МХБ-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 05-р сарын 05-ны өдрийн А/42 тоот тушаалаар Компанийн үнэт цаасыг ангилал ахиулан II дугаар ангилалд бүртгэсэн.

2023 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар МХБ, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгэгдсэн Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны тоо 817,768,643, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо 9,615 байсан. Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн ээлжит бус хурлаар шинээр 296,483,391 энгийн хувьцаа гаргахаар шийдвэрлэж, тус шийдвэрийн дагуу 2024 оны 01-р сард шинэ хувьцааг холбогдох зохицуулагч байгууллагуудад бүртгүүлж дууссанаар Компанийн гаргасан энгийн хувьцааны тоо 1,114,252,034 ширхэг болж, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо [] болсон. Компанийн нөлөө бүхий болон олон нийтийн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл болон Компанийн бүтцийг дор харуулав.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Хувьцаа эзэмшигчид	2023 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар	
	Эзэмшлийн хувьцааны тоо	Эзэмшлийн хувь
А.Ганхуяг	258,776,832	31.64%
А.Ганболд	172,327,784	21.07%
Ц.Баяржаргал	88,164,258	10.78%
БиЖиЭф Ритэйл Ко., Лтд.	67,980,767	8.31%
Олон нийт	230,519,002	28.19%
Нийт	817,768,643	100%

Үзүүлэлт	2022/12/31	2023/12/31	2024/03/31
Нийт хувьцааны тоо	817,768,643	817,768,643	1,114,252,034
Хувьцаа эзэмшигчийн тоо	10,108	9,615	

Хүснэгт 15 . Хувьцаа

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн тухай хууль болон Компанийн Дүрмийн холбогдох заалтуудын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

Компанийн тухай хуулийн холбогдох заалтууд, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-өөс баталсан Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах журам болон Санхүүгийн зохицуулах хорооны Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04-р сарын 29-ний өдрийн 12:00 цагт цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулсан бөгөөд тус хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 84.94 хувь нь оролцож Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны тайлан болон 2022 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний шалтгаантай танилцаж, 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт, зарласан энгийн хувьцааны тоог 50,956,877 ширхгээр нэмэгдүүлэх, нэмж гаргах энгийн хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэхгүй байх, Компанийн оршин байгаа хаягийг Монгол Улс, Улаанбаатар 13312, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Олимп хороолол, Их Монгол Улсын гудамж 202, Сакура Тауэр, 7-н давхар хэмээн өөрчлөх, нэмэлт өөрчлөлт орсон Дүрмийн төслийг батлах, ТУЗ-ийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгож дахин томилохоор тус тус шийдвэрлэсэн хэдий ч СЗХ-ноос тавьсан шаардлагын дагуу Компанийн зарласан энгийн хувьцааны тоог 50,956,877 ширхгээр нэмэгдүүлэх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар дахин хуралдуулах шаардлагыг тавьсан тул хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх, нэмж гаргах энгийн хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэхгүй байх, Компанийн оршин байгаа хаягийг өөрчлөх, нэмэлт өөрчлөлт орсон Дүрмийн төслийг батлах асуудлууд хэрэгжээгүй.

ТУЗ-ийн шийдвэрээр Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот 17011, Хан-Уул дүүрэг, Махатма Ганди гудамж 39, Корпорэйт Конвеншн Центрийн 5-р давхрын хурлын өрөөнд зарлан хуралдуулж, хурлаар Компанийн зарласан энгийн хувьцааны тоог 264,492,441 ширхгээр нэмэгдүүлэх, нэмж гаргах энгийн хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх, 296,483,391 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган хаалттай хүрээнд стратегийн хөрөнгө оруулагчдад эзэмшүүлэх, Компанийн оршин байгаа хаягийг Монгол Улс, Улаанбаатар 13312, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Олимп хороолол, Их Монгол Улсын гудамж 202, Сакура Тауэр, 7-н давхар хэмээн өөрчлөх, Компанийн "Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК" оноосон нэрийг "Премиум Нэксус ХК" хэмээн өөрчлөх, Компанийн нэмэлт өөрчлөлт орсон Дүрмийн төслийг батлах, ТУЗ-ийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгож дахин томилохоор тус тус шийдвэрлэсэн бөгөөд эдгээр шийдвэрүүдийг хэрэгжүүлэх зөвшөөрлийг МХБ-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 12-р сарын 28-ны өдрийн А/348 тоот тушаал, СЗХ-ны 2024 оны 01-р сарын 12-ны өдрийн 02 тоот тогтоол, 2024 оны 02-р сарын 24-ний өдрийн 48 тоот тогтоолоор тус тус олгосны дагуу Компани нь холбогдох өөрчлөлтүүдийг зохицуулагч байгууллагуудад 2024 оны 02-р сарын 28-ны өдөр бүрэн бүртгүүлж дууссан байна.


ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ

Компани нь хувьцаа эзэмшигчдийнхээ эрхийг хангах үүднээс тайлант хугацаанд хуралдуулсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлуудын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэсэн бөгөөд хувьцаа эзэмшигчдийг хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой танилцуулга материалтай танилцах, <https://hural.cumongol.mn> веб хаягаар хуралд бүртгүүлэх, урьдчилан санал өгөх боломжоор хангаж ажилласан. Мөн эдгээр хурлуудад ТУЗ-ийн бүх гишүүд, Гүйцэтгэх удирдлагыг оролцуулж хурлаар хэлэлцсэн асуудлуудтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулт, тодруулга өгсөн бөгөөд ээлжит хуралд Компанийн хараат бус аудитор ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК-ийн төлөөлөгчид оролцож Компанийн 2023 оны санхүүгийн жилийн тайлангийн хараат бус аудиторын тайлан, дүгнэлт, дүгнэлтийн үндэс, хараат бус байдал, аудитын арга барил, аудитын гол асуудлууд болон бусад холбогдох асуудлуудыг танилцуулсан байна.

G1.2: Удирдах зөвлөлийн хараат бус байдал	Удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь	33.33% (1/3)
-------------------------------------------	---------------------------------------------------	--------------

ХУВЬЦААНЫ ГҮЙЦЭТГЭЛ

2023 оны 12-р сарын 31-ы байдлаар Компанийн зах зээлийн үнэлгээ 121.4 тэрбум төгрөг байсан ба МХБ-ийн зах зээлийн үнэлгээгээр 13 дугаар байранд эрэмбэлэгдэж, нийт зах зээлийн 1.11 хувийг бүрдүүлж байна. MSE:CUMN хувьцаа нь 2023 онд МХБ-ийн хувьцааны арилжааны үнийн дүнгийн эрэмбээр 11 дүгээрт арилжаалагдсан тоо ширхгийн эрэмбээр 4-т тус тус жагссан. 2023 оны байдлаар нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 2.69 хувийг эзэлж байна.



ТУЗ-ИЙН ГИШҮҮД



ГАРИ СТИВЕН БИОНДО

Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo) нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн дарга (хараат бус) бөгөөд Улаанбаатар дах Олон Улсын Дунд Сургуулийн ТУЗ-ийн дарга, Монгол дах АНУ-ын худалдааны танхим (АмЧам Монгол)-ын ТУЗ-ийн дарга, Эдельвайс Арт зочид буудлын гүйцэтгэх захирал юм. Тэрээр 35 гаруй жил зочид буудлын менежментийн салбарт, тэр дундаа ажилчдын сургалтын хөтөлбөр, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын стандарт, чанар, дотоод хяналтын удирдлага, галын аюул, осол үүсэх эрсдэлийн удирдлагын тогтолцоог амжилттай хэрэгжүүлж, хяналт тавьж ажилласан туршлагатай. Гари Биондо нь Азийн өөр өөр соёл иргэншилтэй олон улс орнуудад өндөр зэрэглэлийн Шангри-Ла олон улсын зочид буудал, резортод 28 жил ерөнхий менежер, гүйцэтгэх удирдлагаар ажилласан бөгөөд АНУ-ын Колорадо мужийн Колорадо Коллежийг сонгодог уран зохиол, гүн ухааны чиглэлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.



АДИЛБИШИЙН ГАНХУЯГ

Адилбишийн Ганхуяг нь Премиум Корпорэйшний үүсгэн байгуулагч, Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал бөгөөд сүүлийн 22 гаруй жил Монголын нэр нөлөө бүхий томоохон компаниуд болох М-Си-Эс Группийн Тэргүүн дэд ерөнхийлөгч, М-Си-Эс Холдинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал, М-Си-Эс Кока-Кола ХХК болон Юнител ХХК-ийн ТУЗ-ийн дарга, Монголиан Майнинг Корпорацийн (НКЕХ: 975)-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүү эрхэлсэн дэд ерөнхийлөгч, Улаанбаатар Хотын Худалдааны Танхимын Ерөнхийлөгчөөр ажиллаж ирсэн туршлагатай. Тэрээр эдгээр компаниудын үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх, таниулахад үнэтэй хувь нэмэр оруулж, эрчим хүч, уул уурхай, хөнгөн үйлдвэр, дэд бүтэц, барилга, худалдааны салбарт томоохон хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт татах ажлыг амжилттай удирдан зохион байгуулсан. А.Ганхуяг нь Монгол Улсын Их Сургуулийг санхүү, эдийн засгийн бакалаврын зэрэгтэй төгссөн.



АДИЛБИШИЙН ГАНБОЛД

Адилбишийн Ганболд нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Премиум Корпорэйшний үүсгэн байгуулагч, Премиум Иннова ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн бөгөөд түүний зэргэлдээ, хараат компаниудын үйл ажиллагааг удирдан, стратегийн чиглэл, зорилтыг хэрэгжүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж ирсэн. Монгол Улсын авто зам барилга, хотын дэд бүтцийн компани болох Нэйшнл Девелопер ХХК-ийн Гүйцэтгэх захирал, тансаг зэрэглэлийн тавилга үйлдвэрлэгч Ганброс ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд Ерөнхий захирлаар ажиллаж байсан. Түүний барилгын салбарын хөгжилд оруулж буй хувь нэмрийг төр засгаас өндрөөр үнэлж Алтан гадас одонгоор шагнасан юм. Тэрээр Оросын Холбооны Улсын Харьков хотын Барилгын дээд сургууль, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль ("ШУТИС")-ийг цахилгаан тээвэр, системийн инженер мэргэжлээр суралцсан, бакалаврын зэрэгтэй.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД



ГАНСҮХИЙН БАТ-ЭРДЭНЭ

Гансүхийн Бат-Эрдэнэ нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүү хариуцсан захирал, Премиум Иннова ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүү хариуцсан захирлаар ажилладаг. Тэрээр анхны ажлын гараагаа үйлдвэрлэл, худалдааны салбарт тэргүүлэгч М-Си-Эс Кока Кола ХХК-д санхүү төлөвлөлтийн газрын даргаар эхлүүлж байв. Сүүлийн 20 жилийн хугацаанд өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, уул уурхай, эрчим хүч, аж үйлдвэрлэл, барилгын салбарт ажиллаж, Монголиан Майнинг Корпораци (НКЕХ: 975) болон Премиум Групп ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан бөгөөд М-Си-Эс Энержи ХХК-ийн дэд захирал, Монголиан Майнинг Корпорацийн Санхүү хариуцсан Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан туршлагатай. Г.Бат-Эрдэнэ нь Хан-Уул Дээд Сургуулийг бизнесийн удирдлага, хэрэглээний математикч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.



ЗАЛАА-УУЛЫН УЯНГА

Залаа-Уулын Уянга нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Премиум Корпорэйшнний Хүний нөөцийн төслийн захирал бөгөөд тэрээр хүний эрхийн чиглэлийн олон улсын байгууллага, Нэгдсэн Үндэстний Байгууллагад хүүхэд, залуучуудын эрх, хөгжил, хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийн олон сая долларын хөтөлбөрүүдийн санхүүжилт, менежмент хариуцаж 13 жил ажилласан туршлагатай. Мөн гарааны бизнесийн экосистем хөгжүүлэх Стартап Монгол ТББ-ын Гүйцэтгэх захирал, хүний нөөцийн технологи хөгжүүлэгч Нитотех технологийн компанид Үйл ажиллагаа хариуцсан захирлаар ажиллаж байсан. Тэрээр МУИС-ийг Олон улсын харилцааны бакалаврын зэрэгтэй, Японы Токио дахь ХОУИС-ийг Төрийн удирдлагын магистрын зэрэгтэйгээр тус тус дүүргэсэн.



ГАНБОЛДЫН ЧИНЗОРИГ

Ганболдын Чинзориг нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирлын орлогч юм. Тэрээр программ хангамж, бизнес процесс, бизнес интележенс, мэдээллийн технологийн мастер төлөвлөлт, инженерчлэлийн чиглэлээр ажилласан туршлагатай бөгөөд Мэдээллийн Технологи, Шуудан, Харилцаа Холбооны Газар ("МТШХХГ")-ын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагт Эдийн засгийн бодлогын шинэчлэл ба өрсөлдөх чадварын төслийн мэдээллийн технологийн зөвлөх, Азийн Хөгжлийн Банкны Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх төсөл, Хөрөнгийн зах зээлийн мэдээллийн систем ба санхүүгийн дэд бүтцийн зөвлөхөөр тус тус ажиллаж байсан туршлагатай. Тэрээр МТШХХГ-д ажиллаж байхдаа Цахим засаглал хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулж, Монгол Улсын Харилцаа холбоо, интернэт, шуудан, хэвлэл мэдээлэл, хиймэл дагуулын холбооны талаар баримтлах төрийн бодлого болон Мобайл сүлжээний 4G үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлэх зохицуулалтын бодлогыг боловсруулсан. Г.Чинзориг нь ШУТИС-ийг компьютерын шинжлэх ухааны бакалавр, АНУ-ын Луисвиллийн Их Сургуулийг бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД



БОЛДБААТАРЫН БАТ-ЭРДЭНЭ

Болдбаатарын Бат-Эрдэнэ нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Польшийн Хөгжлийн Сангийн Хөрөнгө Оруулалт Худалдааны Агентлагийн Монгол дах суурин төлөөлөгч, Хорайзон Партнерс ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд хөрөнгө оруулалт, олон улсын хамтын ажиллагаа, худалдааны чиглэлээр 16 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрээр Польш, АНУ, Швейцар улсад сурч, Монголын анхны гадаадын (Японы) хөрөнгө оруулалтын банканд зах зээлийн шинжээчээр, Олон Улсын Санхүүгийн Корпорац болон Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны хөрөнгө оруулалттай Монголын анхны хаалттай хөрөнгө оруулалтын санд (50 сая ам. долларын) зах зээл, бизнесийн шинжээчээр, Польш-Монголын хамтарсан худалдааны компанийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан ба Азийн Хөгжлийн Банкны Монгол улсад "Private Equity" болон "Venture Capital" хөрөнгө оруулалтын сангийн зах зээлийг хөгжүүлэх техник эдийн засгийн үндэслэл боловсруулах зөвлөх компаниар ажилласан хөрөнгө оруулалт, стратеги, менежментийн зөвлөх үйлчилгээний компанийн үүсгэн байгуулагч юм. Б.Бат-Эрдэнэ нь Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийг нягтлан бодох бүртгэлийн бакалаврын зэрэгтэйгээр төгссөн.



ӨЛЗИЙСҮРЭНГИЙН ЭРДЭНЭЧИМЭГ

Өлзийсүрэнгийн Эрдэнэчимэг нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд нийгэм, эдийн засаг, байгаль орчин, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн чиглэлээр дагнан судалгаа, үнэлгээ хийдэг Когнос Интернэйшнл ХХК-ийн Захирал, үүсгэн байгуулагч юм. Тэрээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, ЮНЕСКО, Европын холбоо гэх мэт олон улсын байгууллагууд болон төр, хувийн хэвшлийн бодлого, хөтөлбөр, стратеги мөн Тогтвортой хөгжлийн зорилгын судалгаа, үнэлгээ дээр сүүлийн 14 жил ажиллаж байна. Эрдэнэчимэг нь Монголын үнэлгээний холбооны үүсгэн байгуулагч, ТУЗ-ын дарга бөгөөд Америкийн үнэлгээний холбоо, Монголын үнэлгээний холбооны Нийгмийн нөлөөллийн хэмжилт ба Байгаль орчин, нийгэм, засаглалын салбар бүлгийн гишүүн, Үнэлгээний хамтын ажиллагааны төлөөх олон улсын байгууллага (IOCE), Ази номхон далайн үнэлгээний холбоо (APEA)-ны Үнэлгээг мэргэжлийн түвшинд хөгжүүлэх ажлын хэсгийн гишүүнээр тус тус ажилладаг. Эрдэнэчимэг нь МУИС-д хүн амзүйн докторант ба Английн Лондоны Эдийн Засгийн Сургуульд нийгмийн судалгааны аргазүйн магистр, Тайландын Махидолын Их Сургуульд хүн ам, нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгааны магистр зэрэг тус тус хамгаалсан.



ВАНЧИГИЙН ГАНЗОРИГ

Ванчигийн Ганзориг нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд стратеги ба коммуникацийн чиглэлээр мэргэшсэн Бат Солюшн Партнерс ХХК-ийн Удирдах зөвлөлийн дарга, "CEO" клубийн ерөнхийлөгч, Монголын Дауны Холбоо, Менторшипийн залуу мэргэжилтнүүдийн хөтөлбөрийн тэргүүн, Монголын Тусгай Олимпын Хорооны Удирдах зөвлөлийн гишүүн, "Global Teacher Prize"-ийн академийн гишүүн, Синдикат ярилцлага нэвтрүүлгийн модератор, тэргүүлэх мэдээллийн сайтуудын нийтлэлчээр ажилладаг. Тэрээр Худалдаа Хөгжлийн Банк, ХасБанк, МОСДАК, Шунхлай Группийн удирдлагын багт ажиллаж байсан туршлагатай бөгөөд Дэлхийн Эдийн Засгийн Форумын 2014 оны дэлхийн залуу манлайлагчаар шалгарсан. В.Ганзориг нь Японы Олон Улсын Их Сургуулийг цахим бизнесийн удирдлагын магистр, Австралийн Нотре Даме Их Сургуулийг бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн бөгөөд АНУ (Virginia, Yale), Англи (Oxford), Өмнөд Африк (WITS, Cape Town), Сингапур (NUS) улсуудад удирдлага, манлайлал, бодлогын инновац, гео улс төр, өөрчлөлтийн менежмент чиглэлээр мэргэжлийн сургалтуудад хамрагдсан Монголын Улсын мэргэшсэн зөвлөх юм.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН БҮТЭЦ, ТҮҮНИЙ ХОРООД

ТУЗ нь хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудад урт хугацааны үнэ цэнийг бий болгох зорилгоор хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолд нийцүүлсэн үндсэн үйл ажиллагааны чиглэл, бодлого, стратегийг тодорхойлж, гүйцэтгэх удирдлагыг Компанийн зорилго, зорилт, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдан чиглүүлж, хяналт тавин ажилладаг. ТУЗ нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд эдгээр гишүүдийн 6 нь ердийн, 3 нь хараат бус гишүүд юм.

ТУЗ нь ТУЗ-ийн гишүүн О.Батмөнх, хараат бус гишүүн Н.Энхболд нарыг 2023 оны 10-р сарын 24-ний өдрөөр үүрэгт ажлаас чөлөөлсөн бөгөөд Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд, мөн ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу З.Уянга-г ТУЗ-ийн гишүүн, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо болон Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо ("БОНЗ-ын хороо")-ны гишүүнээр, Ө.Эрдэнэчимэгийг ТУЗ-ийн хараат бус гишүүн, БОНЗ-ын хорооны даргаар түр томилсон. Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 12-р сарын 04-ний өдөр зохион байгуулагдсан ээлжит бус хурлаар ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь үүрэгт ажлаас чөлөөлж дахин сонгосноор ТУЗ-ийн гишүүд шинээр томилогдсон. Түүнчлэн Компанийн үйл ажиллагааг нээлттэй байлгах, хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг дээдлэх зорилгын хүрээнд, мөн 2023-2024 онуудад Компанийн бүтцэд өөрчлөлт орж, бизнесийн цар хүрээ өргөжсөнтэй холбогдуулан ТУЗ-ийн хараат бус гишүүн Гари Биондог 2023 оны 12-р сарын 11-ний өдөр БОНЗ-ын хорооны гишүүн, 2024 оны 03-р сарын 01-ний өдөр ТУЗ-ийн (хараат бус) даргаар тус тус томилоод байна. ТУЗ нь тогтвортой хөгжлийн зорилт болон Хүний эрхийн зарчмуудыг баримтлал болгон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэй гишүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд хүчин чармайлт гарган ажилласан бөгөөд, ТУЗ-ийн бүрэлдэхүүнд шинээр 2 эмэгтэй гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлэн томилуулсан. Түүнчлэн 2023 оны байдлаар Компанийн нийт ажиллагсдын дундаас дээш удирдлагын 48 хувь, ханган нийлүүлэгчдийн нийт ажиллагсдын хувьд 76 хувь нь эмэгтэй байна.

Компани нь шинээр томилогдсон ТУЗ-ийн гишүүдэд Компанийн үйл ажиллагаа, бизнес, дүрэм журмыг танилцуулан, чиглүүлэх сургалтыг хийсэн бөгөөд ТУЗ болон түүний хороодын бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийг тухай бүр СЗХ болон МХБ-д мэдэгдэж, МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан мэдээлж мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан.

№	Овог нэр	Хүйс	Албан тушаал
1	Гари Биондо	Эр	ТУЗ-ийн дарга, (хараат бус)
2	А.Ганхуяг	Эр	ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал
3	Г.Чинзориг	Эр	ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирлын орлогч
4	А.Ганболд	Эр	ТУЗ-ийн гишүүн
5	Г.Бат-Эрдэнэ	Эр	ТУЗ-ийн гишүүн
6	Б.Бат-Эрдэнэ	Эр	ТУЗ-ийн гишүүн
7	З. Уянга	Эм	ТУЗ-ийн гишүүн
8	В. Ганзориг	Эр	ТУЗ-ийн хараат бус гишүүн
9	Ө.Эрдэнэчимэг	Эм	ТУЗ-ийн хараат бус гишүүн

Хүснэгт 16. ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл

ТУЗ-ИЙН ГИШҮҮД

ТУЗ-ийн гишүүний нэр	Эзэмшиж буй хувьцааны тоо		Нийт хувьцаанд эзлэх хувь	
	Шууд	Шууд бус	Шууд	Шууд бус
Гари Биондо (дарга, хараат бус)	–	–	–	–
А.Ганхуяг	258,776,832	7,857,856	31.64%	0.96%
А.Ганболд	172,327,784	5,982,780	21.07%	0.273%
Г.Бат-Эрдэнэ	19,948,820	658,979	2.44%	0.08%
З-Уянга	–	–	–	–
Г.Чинзориг	44,150	–	0.01%	–
Б.Бат-Эрдэнэ	80,000	–	0.01%	–
Ө.Эрдэнэчимэг	–	–	–	–
В.Ганзориг	2,709	–	0.00%	–

ТУЗ-ийн гишүүдийн хувьцаа эзэмшлийн хувь хэмжээ (2023 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар)

ТУЗ-ИЙН ХОРООД

Тус компани нь Компанийн тухай хуулийн 81-д заасны дагуу ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулж үйл ажиллагааг нь хууль болон холбогдох журамд нийцүүлэн зохион байгуулж, тайлагнаж байна.

Мөн компанийн алсын хараа, олон улсын хандлага, туршлагыг нэвтрүүлэх үүднээс компанийн дээд удирдлага, бодлого, стратегийн түвшинд БОНЗ-ын хүрээний асуудалд анхаарч ТУЗ-ийн 2022 оны 07 тоот тогтоолоор Байгаль орчин, нийгэм, засаглалын хороог байгуулсан нь:

- Компанийн үйл ажиллагаа хүлэмжийн хийн ялгарал ба байгаль орчинд , хүлэмжийн хийн ялгарал ба байгаль орчин компанийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгаа,
- Компанийн үйл ажиллагаа хүний эрх ба нийгэмд, хүний эрх ба нийгэм компанийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгаа,
- Компанийн үйл ажиллагаа компанийн соёл ба оролцогч талуудад, компанийн соёл ба оролцогч талууд компанийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг хянаж, удирдах боломжийг олгохоос гадна цаашдын бизнесийн тогтвортой, тасралтгүй байдлыг хангах, эрсдэлийн удирдлагыг илүү сайжруулах, хөрөнгө оруулагчдыг татахад чухал ач холбогдолтой.

№	ТУЗ-ийн дэргэдэх хороод	Гишүүдийн нэр	Албан тушаал
1	Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо	Ө.Эрдэнэчимэг	Хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн
		Гари Биондо	ТУЗ-ийн дарга (хараат бус)
		З.Уянга	ТУЗ-ийн гишүүн
2	Нэр дэвшүүлэх хороо	В. Ганзориг	Хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн
		А. Ганхуяг	ТУЗ-ийн гишүүн
		З.Уянга	ТУЗ-ийн гишүүн
3	Цалин урамшууллын хороо	Гари Биондо	Хорооны дарга, ТУЗ-ийн дарга (хараат бус)
		А. Ганболд	ТУЗ-ийн гишүүн
		З.Уянга	ТУЗ-ийн гишүүн
4	Аудитын хороо	В.Ганзориг	Хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн
		Гари Биондо	ТУЗ-ийн дарга (хараат бус) гишүүн
		Г. Бат-Эрдэнэ	ТУЗ-ийн гишүүн

Хүснэгт 17. ТУЗ-ийн дэргэдэх хороод

ТУЗ-ИЙН ХОРООД

Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо

БОНЗ-ын хороо нь Компанийн байгаль орчин, нийгэм, засаглал ("БОНЗ")-ын алсын хараа, стратеги, бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэхэд хяналт тавих; БОНЗ-ын шинээр гарч ирж буй чиг хандлага, асуудлуудыг хянаж үзэх, үүний дагуу Компанийн БОНЗ-ын талаарх алсын харааг боловсруулах, заавар зөвлөмжийг өгөх; аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах, нийгмийн хариуцлага, компанийн засаглалын талаарх Компанийн бодлогыг тодорхойлох, түүнд шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах; ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын сургалт, тасралтгүй мэргэшлийн өсөлтөд хяналт тавих, хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөх бодлого, журам, гарын авлага, ёс зүйн дүрмийг боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг хянах, ТУЗ болон түүний хороодын үйл ажиллагаа, ТУЗ-ийн гишүүдийн оруулсан хувь нэмрийг тогтмол үнэлж, ТУЗ-д зөвлөмж гаргах үүрэгтэй. БОНЗ-ын хороо нь ТУЗ-ийн ердийн гишүүн З.Уянга, ТУЗ-ийн хараат бус гишүүд Ө.Эрдэнэчимэг, Гари Биондо нараас бүрдсэн гурван гишүүнтэй бөгөөд Ө.Эрдэнэчимэг нь тус хорооны дарга юм.

Аудитын хороо

Байгууллагад үр дүнтэй дотоод хяналтын тогтолцоог бий болгох буюу бизнесийн үр ашигтай захиран зарцуулах дотоод хяналтыг хэрэгжүүлэх, Компанийн эд хөрөнгийг хамгаалах, нягтлан бодох бүртгэлийн зохих бүртгэл хөтлөх, санхүүгийн мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангах, түүнчлэн үйл ажиллагааны гол үзүүлэлтүүдийг харьцуулах зэрэг санхүүгийн бус асуудлуудтай холбоотой бизнесийн удирдлагын дотоод хяналтын тогтолцоо, ёс зүйн хэм хэмжээг бий болгох, хадгалахад чиглэсэн санал зөвлөмжийг ТУЗ-д гаргах үүрэгтэй. Аудитын хороо нь ТУЗ-ийн ердийн гишүүн Г.Бат-Эрдэнэ болон ТУЗ-ийн хараат бус гишүүд болох В.Ганзориг, Гари Биондо нараас бүрдсэн гурван гишүүнтэй бөгөөд В.Ганзориг нь тус хорооны дарга юм.

Цалин урамшууллын хороо

Цалин урамшууллын хороо нь ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулал, нөхөн олговортой холбоотой зохицуулалтыг тодорхойлох, хяналт тавих, өндөр ур чадвартай ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг урт хугацаанд хадгалж ажиллуулах замаар хувьцаа эзэмшигчдийн ашгийг их байлгах ерөнхий зорилгын хүрээнд эдгээр эрх бүхий албан тушаалтнуудын урамшууллын хэлбэр, хэмжээ нь зохистой байгаа эсэхийг хөдөлмөрийн зах зээлийн холбогдох нөхцөл байдалд үндэслэн үнэлэх үүрэгтэй юм. Цалин урамшууллын хороо нь ТУЗ-ийн ердийн гишүүн А.Ганболд, З-Уянга, ТУЗ-ийн хараат бус гишүүн Гари Биондо нараас бүрдсэн гурван гишүүнтэй бөгөөд Гари Биондо нь тус хорооны дарга юм.

Нэр дэвшүүлэх хороо

Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн сул орон тоог нөхөх Компанид шаардлагатай мэдлэг, ур чадвартай нэр дэвшигчдийг олж тодорхойлох, тэдгээрийг ТУЗ-д танилцуулах, санал, зөвлөмж гаргах үүрэгтэй. Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүн А.Ганхуяг, ТУЗ-ийн ердийн гишүүн З.Уянга, ТУЗ-ийн хараат бус гишүүн В.Ганзориг нараас бүрдсэн гурван гишүүнтэй бөгөөд В.Ганзориг нь тус хорооны дарга юм.

ТУЗ-ИЙН ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компанийн ТУЗ нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу үйл ажиллагаа явуулж байна. Тайлант хугацаанд ТУЗ нь 4 удаа 100 хувийн ирцтэйгээр хуралдаж Компанийн урт болон богино хугацааны стратеги төлөвлөгөө, жилийн болон улирлын үйл ажиллагаа, санхүүгийн гүйцэтгэл, төсөв, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн бөгөөд тайлант хугацаанд Компанийн үйл ажиллагаа, гүйцэтгэх удирдлагын болон компанийн засаглалын дотоод асуудлууд, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох, ногдол ашиг хуваарилах эсэх, Компанийн хувьцааг нэмж гаргах, стратегийн хөрөнгө оруулалт татах, БОНЗ тайлан, охин компанийг байгуулах, Компанийн оноосон нэр, оршин байгаа хаягийг өөрчлөх, Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг төрөл бүрийн асуудлуудыг хэлэлцэн нийт 39-н шийдвэр тогтоол гарган ажилласан. Түүнчлэн ТУЗ нь ТУЗ-ийн хороодын зөвлөмжийн дагуу Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны журам, Авлигын эсрэг үйл ажиллагааны журам болон Ашиг сонирхлын зөрчлийг мэдүүлэх, шийдвэрлэх журам Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг шинээр баталсан.

Эрх бүхий албан тушаалтан

ТУЗ-ийн дарга, гишүүд болон нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Гүйцэтгэх захирлын орлогч, Санхүү хариуцсан захирал нар нь Компанийн эрх бүхий албан тушаалтнууд юм.

Эрх бүхий албан тушаалтнуудад 2023 онд олгосон сарын цалин урамшууллын хэмжээг татварын өмнөх үнийн дүнгээр багцлан доорх хүснэгтэд харуулав.

ТУЗ-ийн гишүүд	ТУЗ		БОНЗ-ын хороо		Нэр дэвшүүлэх хороо		Цалин урамшууллын хороо		Аудитын хороо		Хувьцаа эзэмшигчдийн хурал
	Хурлын тоо/ирц	Тогтоолын тоо	Хурлын тоо/ирц	Зөвлөмжийн тоо	Хурлын тоо/ирц	Зөвлөмжийн тоо	Хурлын тоо/ирц	Зөвлөмжийн тоо	Хурлын тоо/ирц	Зөвлөмжийн тоо	Хурлын тоо/ирц
Гари Биондо (дарга, хараат бус)	4/4	39/39	0/0	4/4	-	-	0/0	11/11	4/4	12/12	2/2
А.Ганхуяг	4/4	39/39	-	-	0/0	9/9	-	-	-	-	2/2
А.Ганболд	4/4	39/39	-	-	-	-	0/0	11/11	-	-	2/2
Г.Бат-Эрдэнэ	4/4	39/39	-	-	-	-	-	-	4/4	12/12	2/2
З-Уянга	4/4	39/39	0/0	4/4	0/0	1/1	0/0	0/0	-	-	1/1
Г.Чинзориг	4/4	39/39	-	-	-	-	-	-	-	-	2/2
Б.Бат-Эрдэнэ	4/4	39/39	0/0	4/4	-	-	-	-	-	-	2/2
Ө.Эрдэнэчимэг	4/4	39/39	0/0	0/0	-	-	-	-	-	-	1/1
В.Ганзориг	4/4	39/39	-	-	0/0	9/9	-	-	4/4	12/12	2/2

Хүснэгт 18. ТУЗ болон ТУЗ-ийн хороодын дарга, гишүүдийн хуралд оролцсон ирц

	Хэмжих нэгж	2021 он	2022 он	2023 он
ТУЗ-ийн хэлэлцсэн асуудлын тоо	Тоо	24	37	39
ТУЗ-ийн хороодын зөвлөмжийн тоо	Тоо	-	32	36
ТУЗ-ийн хараат бус гишүүдийн ирц	Хувь	100	100	100
Гүйцэтгэх захирлын ирц	Хувь	100	100	100

Хүснэгт 19. ТУЗ-ийн хурал




График 10. ТУЗ-ийн хурал

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮНЭЛГЭЭ

Санхүүгийн зохицуулах хороо “Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээг 2023 оны хагас хагас жилийн байдлаар 93.1 хувьтай буюу засаглал “САЙН” гэж дүгнэсэн байна. Жилийн эцсийн байдлаар кодексийн гүйцэтгэлийн үнэлгээ 95 хувь болж нэмэгдсэн бөгөөд компанийн зүгээс ТУЗ-ийн дэргэдэх хороодыг Хараат бус гишүүдээс томилох, дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг анхаарч үнэ цэнийг нэмэгдүүлэх чиглэлд ажиллаж байна.

“Компанийн засаглалын кодекс”-ийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг баталсан бөгөөд хэрэгжилтийг хангах болон тайлагналыг сайжруулах тал дээр анхааран ажиллаж байна.

№	Агуулга	Авбал зохих нийт оноо	Авсан оноо, 2022	Үнэлгээний хувь, 2022	Авсан оноо, 2023	Үнэлгээний хувь, 2023
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	100%	12	100%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	8	80%	9	90%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6	6	100%	6	100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	5	83%	5	83%
5	Эрсдэлийн удирдлага	8	8	100%	8	100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшуулал	6	6	100%	6	100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%	8	100%
8	Компанийн соёл	6	6	100%	6	100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9	90%	9	90%
	Нэгдсэн дүн	72	68	94,8%	69	95%

Хүснэгт 20. Компанийн засаглалын кодексийн үнэлгээ, 2022, 2023

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮНЭЛГЭЭ



ТУЗ-ИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

ТУЗ-ийн гүйцэтгэлийг 3 бүлэг, 15 дэд бүлгийн нийт 99 шалгуур үзүүлэлтээс хэмжиж үнэлгээ өгдөг бөгөөд 2023 онд сонголттой болон хамааралгүй 19 үзүүлэлтийг хасаж 80 үзүүлэлтээр үнэлгээ хийсэн. Энэхүү үнэлгээгээр ТУЗ-ийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахаас гадна үр дүнд суурилсан гүйцэтгэлд илүү чиглүүлэх, хянах сайжруулах замаар ТУЗ-ийг илүү идэвхжүүлэх, амжилтыг урамшуулах, хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг илүү сайн хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна.

№	Үнэлгээний агуулга	Хэрэгжилт 2022 он, хувь	Хэрэгжилт 2023 он, хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	-	94%
2	ТУЗ-ийн бүрэн эрх, үүргийн хэрэгжилт	-	81%
3	ТУЗ-ийн хурал, шийдвэр гаргалт	-	95%
	Нэгдсэн дүн	-	90%

Хүснэгт 21. ТУЗ-ийн гүйцэтгэлийн үнэлгээ




График 12. ТУЗ-ийн гүйцэтгэлийн үнэлгээ

АВЛИГА БА ЁС ЗҮЙ

Тус компанийн тухайд Авлига, мөнгө угаах, улс төрийн хамаарал, терроризмыг санхүүжүүлэх зэргээс ангид байх зохицуулалт, бодлогыг хэрэгжүүлэх үүднээс авлигатай тэмцэх болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, хэрэгжүүлэх ерөнхий зарчим, стандартыг тогтоох зорилгоор “Компанийн ёс зүйн дүрэм”, “Авлигын эсрэг үйл ажиллагааны журам”-ыг батлан мөрдүүлж эрх бүхий албан тушаалтан, ажилтан үйл ажиллагаандаа баримтлах, хэвшүүлж байна. Дээрх журмуудын хүрээнд болзошгүй аливаа зөрчил ба үйлдэл, эс үйлдлийг мэдээлэх шүгэл үлээгч байх талаарх заалтыг мөн тусгасан байна.

Мөн “Ашиг сонирхлын зөрчлийг мэдүүлэх журам”-ыг ТУЗ-аас 2023 оны 6 дугаар сард баталж компанийн удирдах, эрх бүхий албан тушаалтнууд, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд хооронд үүссэн, үүсэж болзошгүй ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлох, хянах, шийдвэрлэх замаар компанийн өнөөгийн ба ирээдүйн бизнесийн үнэ цэн, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэх, хэрэв зөрчсөн тохиолдолд хариу арга хэмжээг тодорхойлон заасан байна.

G2.1: Авлига, хээл хахуулийн эсрэг бодлого журам	Авлигын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу?	Тийм
--------------------------------------------------	----------------------------------------------------	------

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Премиум Нэксус ХК нь Монгол улсын холбогдох хууль тогтоомж, СЗХ болон МХБ-ээс батлагдсан дүрэм журмын хүрээнд зохицуулагдсан мэдээ, мэдээллүүдийн ил тод байдлыг хангахаас гадна ОУ-д мөрдөгддөг стандартын хүрээнд ил тод байдлыг хангахаар хичээж бодлогын баримт бичгүүдийг батлан мөрдөж ажилласан байна. Тус компанийн зүгээс “Мэдээлэл хүргэх үйл ажиллагааны журам” мөн Цахим мэдээллийн аюулгүй байдлын журмыг баталж мэдээллийн зохистой хэрэглээ, системийн хэвийн, найдвартай ажиллагааг хангах, мэдээллийн алдагдлаас үүсэх эрсдэлийг бууруулах мөн эрх бүхий байгууллагуудад болон хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд шаардлагатай мэдээллийн төрөл, ангилал, давтамж зэргийн зохицуулалтыг групп компанийн хэмжээнд зохион байгуулан мөрдөж байна. 2023 оны хувьд компанийн оноосон нэр, хаяг байршил, хувьцааны тоо, компанийн дүрэм, ТУЗ-ийн бүрэлдэхүүн, эрх бүхий албан тушаалтан, хараат бус нягтлан бодогч өөрчлөгдсөн зэргийг тухай бүр мэдээлж олон нийтэд хүргэсэн.

ОЛОН НИЙТИЙН ХАРИЛЦАА

Премиум Корпорэйшн ХХК-ийн Гүйцэтгэх захирлын тушаалаар групп компанийн хэмжээнд олон нийттэй хэрхэн харилцах талаарх бодлогын баримт бичгийг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд үйл ажиллагаа явуулж байгаа бүс нутаг дах соёлын өв, зараг захиргаа, ард иргэдтэй харилцааг зохицуулахаас гадна үйл ажиллагаа явуулж байгаа тухайн бүс нутагт учирч болох болзошгүй сөрөг нөлөөллийг зөвшөөрөгдөх хамгийн боломжит бага төвшинд байлгах зорилтыг хангахаар заасан байна. Харин харилцагч, үйлчлүүлэгч, ажилтнаас ирэх санал, гомдол шийдвэрлэх зохицуулалтыг “Call center” болон “Үйлчлүүлэгчийн санал, гомдлыг шийдвэрлэх журам” -аар зохицуулахаар тусгасан байна.

КОМПЛАЕНС

Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-өөс “Комплаенсын хяналтын заавар”-ыг баталсан бөгөөд компанийн үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас баталсан журам, стандарт, зааварт нийцүүлэх, тус хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх бие даасан нэгжийг байгуулж тогтвортой ажиллуулах зохицуулалтуудыг тусгасан байна. Компанийн үйл ажиллагаатай холбоотой зарим стандарт болон тусгай зөвшөөрлүүдийг дурдвал:

- Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ, ерөнхий шаардлага-MNS 5021;2019,
- Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим-MNS CAC/RCP1:2003,
- Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо-MNS ISO22000:2019,
- Архи, тамхины тусгай зөвшөөрөл,
- Аюулын дун шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо зэрэг байна.

G3.1: Комплаенсын бодлого	Комплаенсын бодлого, журам бий юу?	Тийм
G3.2: Комплаенсын хөтөлбөр	Комплаенсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу?	Тийм





САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ ХӨДӨӨ АЖ АХУЙ & ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

CU компанийн “Эрүүл ахуйн тухай журам”-д шавьжгүйтэл, мэрэгчгүйжүүлэлт, халдваргүйжүүлэлтийг тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагаар хийлгэнэ гэж заасан. Үүний дагуу дэлгүүр, хүнсний үйлдвэрт нь Монгол улсын эмийн бүртгэлд орсон ариутгал, халдваргүйжүүлэлт тогтмол хийгддэг.





AF 1: Устгалын бодис	Устгалын бодис ашиглах бодлого журам бий юу?	тийм
AF 2: Тогтвортой газар, бэлчээр	MNS 6891:2020, Хариуцлагатай нүүдэлчин стандарт тогтвортой бэлчээрийн стандартыг хэрэгжүүлж чадсан бэлчээрийн талбайн хувь	n/a
AF 3: Буцаан татан авсан бараа бүтээгдэхүүн	Хүнсний чанар, аюулгүй байдлыг хангаагүй буцаагдсан эсвэл худалдах боломжгүй болсон бүтээгдэхүүний хувь	0.035% (103,609,484ш)

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДАД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

Премиум Нэксус ХК нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчин, нийгэм, эдийн засагт бодитой эерэг хувь нэмэр оруулж, хувьцаа эзэмшигчдийнхээ итгэл найдварыг өндөрт хадгалж, салбартаа манлайлж ажиллахыг зорьж байна. Энэ хүрээнд НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17 зорилгын 9 зорилгод дараах байдлаар хувь нэмрээ оруулж байна. (тоон дата мэдээлэл 2023 оны 2 сарын байдлаар)

 <p>Ядуурлыг устгах</p>	<p>Премиум Нэксус ХК нь байгуулагдсан цагаасаа иргэн бүр ажиллах боломжтой, уян хатан цагийн хуваарь бүхий ажлын байруудыг бий болгож, улмаар орлогын шинэ эх үүсвэртэй болох боломжийг иргэдэд нээлттэй санал болгосоор байгаа. Өрхийн гишүүн бүр орлогын эх үүсвэртэй болох нь ядуурлыг бууруулахад маш чухал үр дүнтэй юм.</p> <ul style="list-style-type: none"> • 5 жилийн хугацаанд 18,000 гаруй хүнийг ажлын байраар хангаж • Нийт 21,597,923 хүн цагийн ажил бий болгосон • Нийт ажилтнуудын 62% нь цагийн ажилтан
 <p>Өлсгөлөнг устгах</p>	<p>CU сүлжээний 374 салбараар өдөр бүр 150,000 орчим үйлчлүүлэгч үйлчлүүлж, дунджаар 73,000 ширхэг хүнсний аюулгүй байдлын бүрэн хяналт дор үйлдвэрлэгдсэн хоолыг худалдан авч байна. Улмаар сүлжээний хэмжээнд борлуулагдаж буй нийт хоолны 38 хувийг CU хоолны үйлдвэрт үйлдвэрлэдэг бол, 62 хувийг дотоодын хоол үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд нийлүүлж хоол хүнсний жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн дэмжин ажиллаж байна.</p>
 <p>Эрүүл мэндийг дэмжих</p>	<p>Нийт хүн амд хүнсний аюулгүй байдлын стандартуудыг хангасан бүтээгдэхүүнээр үйлчлэхээс гадна 2023 онд улсын хэмжээнд яаралтай мэс ажилбар хийлгэх шаардлагатай мэдрэл болон зүрх судасны хүнд, хөнгөн хэлбэрийн оноштой хүмүүс тогтмол үйлчлүүлдэг Шастины нэрэмжит Улсын 3-р эмнэлгийн Мэдрэл болон Зүрхний мэс заслын хүлээлгийн танхимыг засварлан тохижуулж эмнэлгийн хамт олонд хүлээлгэн өгсөн.</p>
 <p>Чанартай боловсролыг дэмжих</p>	<p>Премиум Нэксус ХК нь эмэгтэй ажилтнуудыг удирдах, манлайлах чиглэлд сурч хөгжих боломжоор хангадаг бөгөөд нийт манлайллын сургалтын үр ашиг хүртэгчдийн 74.36 хувь нь эмэгтэй ажилтнууд байна. Мөн хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллах хүрээнд хамтран ажилладаг хоолны бүтээгдэхүүн нийлүүлдэг нийлүүлэгч нарын хөгжүүлэх зорилгоор ажлын байрны угтвар нөхцөлийг сайжруулах, эрүүл ахуйн дадлыг байнга мөрдүүлэн ажиллахын тулд “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийг санаачлан эхлүүлж, Улаанбаатар болон Дархан хотод тус тус 6 ААН-г НАССР стандартыг хэрэгжүүлэхэд чиглүүлэн сургалтаар хангаж зөвлөн тусалж ажилласан.</p>

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДАД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

 <p>5 ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ</p> <p>Жендерийн эрх тэгш байдлыг хангах</p>	<p>Нийт ажилтны 70% нь эмэгтэй, 30% нь эрэгтэй байна. Удирдлагын түвшин дэх хүйсийн харьцааг авч үзвэл эмэгтэй ажилтны тоо анхан, дунд удирдах түвшинд 70% , гүйцэтгэх удирдлагын түвшинд эрэгтэй ажилтны тоо 47% байна. Төлөөлөн удирдах зөвлөлд 2023 онд 2 эмэгтэй гишүүн нэмэгдэн орж, эрэгтэй эмэгтэй гишүүний харьцаа 7/2 болсон байна. Эрэгтэй, эмэгтэй ажилчдын цалингийн харьцаа бүх түвшинд 1:1 байна.</p>
 <p>6 БАТАЛГААТ УСНЫ УС АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖААР ХАНГАХ</p> <p>Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах</p>	<p>CU 365 гаруй салбараар эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн үйлчилгээгээр хангаж, ус хэмнэх мэдрэгчтэй угаалтуур болон суултуурын усны таталтыг 50% -р бууруулсан арга хэмжээ авсан. Үйл ажиллагаандаа ус хэмнэлттэй технологийг суурилуулах арга хэмжээг авснаар 1 сая төгрөг тутам дах борлуулалтад ноогдох усны хэрэглээг 5м³ байснаас 2м³ болгон бууруулж чадлаа.</p>
 <p>7 СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ</p> <p>Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх</p>	<p>2023 онд 1 сая төгрөгийн борлуулалт тутам дахь эрчим хүчний хэрэглээг өмнөх оноос 2.36%-аар бууруулж чадсан байна. Мөн хоол үйлдвэрлэлийн хэсэгт 10м³ хийн түлш хадгалах сав, 500 литрийн дундын сав бүрэн автомат газан хийн байгууламжийн системийг ашиглалтад оруулснаар үйлдвэрийн цахилгаан зарцуулалтыг бууруулж, нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулсан байна.</p>
 <p>8 ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ</p> <p>Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих</p>	<p>Богиносгосон эсвэл бүтэн цагаар хөдөлмөр эрхэлж буй оюутан залуучууд 50 гаруй хувийг эзэлж байгаа бөгөөд дийлэнх олонх нь 18-34 насны залуучууд байна. Компанийн зүгээс ажилтны аюулгүй байдлыг хангахад чиглэсэн олон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд: Бүх дэлгүүрийг камержуулж, салбар дэлгүүрүүдэд гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө боловсруулж, галын тохижилтын арга хэмжээ авч ажилласан. Харуул хамгаалалтын компанитай гэрээ байгуулж хамгаалалт дуудах товчийг дарснаас хойш 10 минутын дотор хамгаалалтын баг ирдэг. CU хоолны үйлдвэр, 2 түгээлтийн төвүүдийн ажилтнууд, оффисын 7 хоног бүр гадуур тогтмол явдаг ажилтнууд гэнэтийн ослын даатгалд хамрагддаг. ХАБЭА сургалт, спортын тэмцээнийг тогтмол зохион байгуулдаг бөгөөд нэг бүрийн хамгаалах хэрэгслээр тогтмол хангадаг.</p>

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДАД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР



Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх

CU аппликэйшн нь дэлгүүрээс өдөр тутмын бүтээгдэхүүн авахдаа аппликэйшн ашиглан бонус оноо цуглуулах, хэрэглэгчдэд зориулсан хямдрал, шагнал урамшуулал зэрэг олон сонирхолтой боломжийг олгож, үнэнч хэрэглээг урамшуулж, бүр илүү хямдаар, бүр олон урамшууллыг санал болгож буй зөвхөн гар утасны аппликэйшнээр дамжуулж харилцах боломжтой болсон нь ихэд дэвшилтэт шийдэл юм. Энэхүү үйлчлүүлэгчийн цагийг хэмнэж, сонголтыг хялбаршуулсан үйлчилгээ 800,538 аппликэйшн хэрэглэгчтэй болсон байна.



Тэгш бус байдлыг бууруулах

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн харилцаанд оролцох тэгш боломжийг бий болгож, найдвартай ажлын байраар хангах нь өөртөө итгэх итгэл, амьдралын идэвхийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй. 2023 онд хөгжлийн бэрхшээлтэй ажилтан нийт ажилтны 4%-ийг эзэлж байсан.



Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих

CU сүлжээ дэлгүүрүүд нь үйлчлүүлэгчдэд гэрээсээ холгүй, ая тухтай, аюулгүй, гэрэлтэй, харуул хамгаалалттай, гадна, доторхоо бүрэн камержуулсан орчныг бүрдүүлж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлд бодитой хувь нэмэр оруулж байна. Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын Гэр бүл хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх газартай хамтран бага насны хүүхдийг төөрөхөөс сэргийлэх, төөрсөн хүүхдийг аюулгүй байлгах, гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилготой хэрэгжүүлж эхэлсэн "CU ЧАМД ТУСАЛЪЯ" хөтөлбөр үргэлжлүүлж, хүүхэд багачуудыг аюул ослоос хамгаалах, төөрсөн хүүхдүүдийг эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгөх зорилготой ICU хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж байна.



Хариуцлагатай хэрэглээг дэмжих

Үйлчлүүлэгчдэдээ үргэлж ариун цэврийн шаардлага хангасан, шинэ туслах хэрэгсэл, хайрцаг савтай бүтээгдэхүүнээр үйлчилдэг. Улмаар эдгээр туслах хэрэгслийн хаягдал нь байгальд орчинд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх зорилгоор бид түргэн устдаг хуванцар таг, дэлхийн ойг хамгаалах Rainforest Alliance сертификат бүхий 540,000ш аягыг хамгийн олноор борлуулагддаг кофендоо ашиглаж байна.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДАД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР



Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах

Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах ажлын хүрээнд мод болон гоёлын цэцгийг тарьснаар, мөн байгальд ээлтэй шингэдэг кофены аягыг хэрэглээ тайлант хугацаанд 540,000 ш ашигласан бөгөөд энэхүү аягыг бусад нийтлэг хэрэглэдэг кофены аягатай харьцуулахад 10,800 кгCO₂e хэмжээгээр хүлэмжийн хийг багасгасан байна. Нийт хүлэмжийн хийн эрчимшлийг тооцож үзвэл 1 хэрэглэгчид үйлчлэхэд 2.19 кгCO₂e, 1,000,000 төгрөгийн борлуулалт бүрд 20.98 кгCO₂e ялгаруулж байна.



Хуурай газрын эко системийг хамгаалах

Нийслэлийн захирагчийн ажлын албанаас зохион байгуулж буй “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцэгжүүлэх” ажлыг Премиум Нэксус ХК нь дэмжин ажиллаж ногоон байгууламжгүй сүлжээ дэлгүүрийн 43 салбарыг хамруулж 75 ширхэг бортоготой цэцэглэдэг мод болон гоёлын цэцгийг тарьж ажилласан.



Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх

Нийслэлийн засаг даргын тамгын газар, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, Дархан уул аймаг, Дархан сумын засаг даргын тамгын газар, HSPIM-Эрүүл мэндийн нийгмийн бодлогын хүрээлэнтэй тогтвортой хөгжлийн төлөө харилцан ойлголцлын санамж бичиг зурж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



БАЯРЛАЛАА

